



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2019.01.17, ПҮРЭВ ~ №011 (1063)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Брекситийн улмаас Т.Мэйд итгэл үзүүлэх эсэх асуудал сөхөгдлөө

Британийн Засгийн газарт итгэл үзүүлэх асуудлаар санал хурааж болзошгүй байдал үүсэв. >9

“Эдийн засаг эргэн хүндрэх магадлал тун ойрхон”

2019 онд инфляцыг анхааралтай ажиглах хэрэгтэй. >11

Шинэ бизнесүүдийн зардлыг цахим худалдаа хэмнэдэг

Дундын зуучлагч байхгүй тул түрээс, нэмэлт зардал төлөх шаардлагагүй. >12

FULL ENGLISH PAGE INSIDE

>7

ОНЦЛОХ

УЛС ТӨР
Батлан даалтад байсан
 Сангийн сайд асан С.Баярцогтыг нэг сар хорьж, шалгахаар болов.
Х.Баттулга прокурорудтай уулзан, экс Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийг шалгуулах хүсэлт тавилаа.
Засгийн газар Асгатын мөнгөний ордыг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэхээр болов.
Агаарын бохирдлын асуудлаарх Ерөнхий хяналтын сонголыг энэ сарын 30-нд хийхээр товлов.

ЭДИЙН ЗАСАГ
Улс орнуудын өр \$244 их наяд болж, түүхэн дээд түвшинд дөхжээ.
“Түмэн шувуут” ХК-ийн нэг бүр нь \$200-ийн үнэтэй 50 сая хувьцааны захиалга эхэллээ.
Овоотын нэг тн коксжих нүүрсний үнэ \$176-\$191 хүрэх боломжтой гэв.
Топ 20 индекс 0.02 хувиар буурч, 21489.22 нэгж боллоо.



НИЙГЭМ
Аэросити, Зуунмод, Майдар хотыг 2040 он хүртэл УБ-ын дагуул хот болгон хөгжүүлнэ.
Тав хүртэлх насны хүүхдэд 3-5 хоног асарсан эцэг, эхэд цалинтай чөлөө олгоно.
СХД-ийн жижиг, дунд үйлдвэрлэгчид бүтээгдэхүүн борлуулах “Дүнжингарав” цэгтэй болов.
Амгалан ДЦС-руу хөрсний ус хальж орох онцгой нөхцөл байдал үүсжээ.

ДЭЛХИЙ
Хятадад Африкийн гахайн ханиад тархсанаас гахайн махны үнэ өссөн байна.
Брекситийн төлөвлөгөө батлагдаагүй тул Европын хувьцааны үнэ сэргэж эхэлжээ.
Вьетнамын Bamboo Airways агаарын тээврийн шинэ компани анхны нислэгээ хийлээ.
Баячуудын зарцуулалт багасан нь өсөлтийг чангааж байна гэж Goldman Sacks мэдээлэв.
Xiaomi лхагва гарагийн арилжаагаар үнэлгээнийхээ \$31 тэрбумыг алдсан байна.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
 2019.01.17


☁️ ☁️

-12° | **-23°**

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЭЭРЭНГҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НҮҮРЭЭС УНШИНА УУ.

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©



Тайландад агаарын чанарын индекс 182-т хүрэхэд гадаа гарахгүй байхыг сэрэмжлүүлэв. Харин Монголд уг үзүүлэлт 1000 нэгж давсан ч дарга нар нүдэн балай, чихэн дүлий байгаа нь монгол хүн утаанд тэсвэртэй гэж үзсэнийх үү, эсвэл... >3

ЗГМ: СЭДЭВ
Гамшгийг хохирол багатай туулах бодит шийдэл хэрэгтэй

З.Цэлмэг
 @tselmegZGM

температур цельсийн 48.9 хэмд хүрч, шөнөдөө 33 хэмээс буухгүй байна.

Уур амьсгалын энэхүү онц ноцтой үзэгдэл наашлаад Зүүн Өмнөд Ази, Номхон далайн эргийн орнуудад үер, хуй сагас зэрэг байгалийн гамшиг тохиож болзошгүй байгааг хэвлэлийнхэн, цаг уурчид, шинжээчид анхааруулж байна. Ази тивд эх дэлхий дээр болж буй байгалийн нийт гамшигт үзэгдлийн 50-60 хувь тохиодог бөгөөд ирээдүйд нийт хохирлын 40 хувь нь ногдоно гэж таамаглаж буй. Байгалийн гамшгийн улмаас дэлхийн эдийн засгийн голлох өсөлтийг хангаж буй энэ тивийн боловсрол, эрүүл мэнд, амьжиргаа зэрэг эдийн засгийн боломжууд хумигдаж байна. Тиймээс ч байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх, хохирол багатай даван туулахад дэлхий нийтийн бодлого тодорхойлогч, хөгжлийн жолоог атгагчдад уриалж буй юм.

УЛС ТӨР
С.Мөнхчулууныг нийслэлийн Засаг даргаар сонголоо

Б.Энхжаргал
 @enkhjgZGM

МАН-ын Удирдах зөвлөл, НИТХ дахь тус намын бүлгээс дэмжсэний дагуу С.Амарсайханыг хотын даргад нэр дэвшүүллээ. Түүний танилцуулгыг НИТХ дахь МАН-ын бүлгийн дарга Р.Дагва төлөөлөгчдөд танилцуулсан юм. Харин тус бүлгийн дарга асан С.Мөнхчулуун өөрийгөө заалнаас нэр дэвшүүлэв.

МАН-ын Удирдах зөвлөл өнгөрсөн сарын 28-нд хуралдан НИТХ-ын дарга С.Амарсайханыг Засаг даргад нэр дэвшүүлэх улс төрийн шийдвэр гаргасан. Харин С.Мөнхчулууны хувьд Удирдах зөвлөлийн шийдвэр гарсан тэр өдрөөс хойш өөрийгөө нэр дэвшүүлэхээр шийдсэнээ энэ үеэр мэдэгдэв. Ийнхүү намын Удирдах зөвлөл, НИТХ дахь бүлгээс дэмжсэн С.Амарсайханаас гадна дахин нэг нэр дэвшигч тодорсон тул УИХ дахь МАН-ын бүлэг завсарлага авч, дотооддоо уг асуудлаа ярилцахаар болсон юм.

НИЙГЭМ
Төр хойрго хандсанаас бизнес эрхлэгчид хохиров

Г.Санжааханд
 ЗГМ

Гахайн мах, махан бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн ашиг, орлогын оргил үе болдог Цагаан сарын баярын өмнөхөн гахайн мялзан өвчин гарч, ийм төрлийн бүтээгдэхүүн худалдаалах боломжгүй боллоо. Улсын онцгой комиссын шийдвэрээр дөрвөн аймгийн таван суманд Африкийн гахайн мялзан өвчин гарсан тул гахайн мах болон өөхийг улсын хилээр оруулж ирэхийг түр хугацаагаар хориглосон. Хэрэв худалдаанд буй гахайн мах, махан бүтээгдэхүүнээс уг өвчин илрэх юм бол худалдааг бүрмөсөн хориглох юм. Энэхүү гэнэтийн шийдвэр нь мах, хиаман бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, бизнесийнхэнд цохилт болжээ. Мах, махан бүтээгдэхүүний борлуулалт Цагаан сарын баярын үеэр энгийн улирлынхаас бараг гурав дахин илүү байдгийг бизнес эрхлэгчид хэлж байна.

АЛТ 1289.66 0.01%	ЗЭС 5920 0.39%	10-ЧИНГИС БОНД 94.26 0.00%	ХУРАЛДАЙ БОНД 107.52 0.1%	ГЭРЭГЭ БОНД 95.63 0.16%	АМ.ДОЛЛАР 2660.12	ЮАНЬ 393.49	РУБЛЬ 39.86
--------------------------------	-----------------------------	---	--	--------------------------------------	-----------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

С.Мөнхчулууныг нийслэлийн Засаг даргаар сонголоо

Санал өгсөн 43 төлөөлөгчийн 24 нь С.Мөнхчулуунд саналаа өгчээ

Гэвч тус бүлгийн авсан 30 минутын завсарлага цайны цагаар үргэлжилж, тэр нь дахин хоёр цагаар сунжирснаар үдээс хойш 15.00 цагийн үед Засаг даргыг сонгох нууц санал хураалт эхлэв.

Нийт 43 төлөөлөгч нууцаар санал өгсөн бөгөөд эхний удаад хоёр нэр дэвшигч тус бүр 21 хүний санал авчээ. Харин нэг төлөөлөгчийн санал хүчингүй гарснаар хоёр дахь санал хураалт зохион байгуулав. Эх сурвалжийн хэлснээр буруу тэмдэглэж, хүчингүй болсон санал С.Амарсайханы нэрийг сонгосон байжээ.

Гэхдээ санал хураалтын явцад төлөөлөгчид нууцаар өгсөн саналынхаа зургийг нь авсан тохиолдол гарчээ. Энэ нь хэнд санал өгч буйгаа санаатайгаар



Б.Хасүй / ЗГМ©

бусад үзүүлэх, хараат бусаар нууц хураалтад оролцох боломжийг хязгаарлаж байна гэж тооллогын комисс үзсэн юм. Тиймээс энэ мэт үйлдлийг төлөөлөгчид гаргавал, өгсөн саналыг нь хүчингүйд тооцох

журам боловсруулж, НИТХ-ын төлөөлөгчдөд танилцуулсан нь багагүй маргаан дэгдэв. Зарим төлөөлөгч “Хүний эрхэд халдаж байна” гэж тооллогын комиссыг буруутгасан ч дээрх журмаар хоёр дахь санал хураалтыг

явуулахаар олонх нь дэмжлээ.

Харин хоёр дахь шатны санал хураалтаар саналаа өгсөн 43 төлөөлөгчөөс 24 нь С.Мөнхчулууны төлөө саналаа өглөө. Өөрөөр хэлбэл, НИТХ-ын төлөөлөгчдийн олонх нь

МАН-ын Удирдах зөвлөл болон НИТХ дахь МАН-ын бүлгийн байр суурийн эсрэг санал өгсөн гэсэн үг юм.

Төлөөлөгчдийн олонх нь МАН-ын бүлгийн эсрэг санал өгөв

Санал хураалт дууссаны дараа С.Мөнхчулуун “Би хамгийн түрүүнд МАН-аас дэвшүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр болох “Аз жаргалтай хот”-ыг 100 хувь биелүүлэхийн төлөө бүх хүчээ дайчлан ажиллана. Мөн агаарын бохирдол, түгжрэл, нийтийн тээврийн асуудлыг шийдэхийн төлөө төлөөлөгчидтэй хамтран ажиллана” гэв.

Түүний нэрийг Ерөнхий сайдад уламжлах бөгөөд хэрэв багламжилбал бүрэн эрхээ шууд хэрэгжүүлэн ажиллах нөхцөл бүрдэнэ. [ЗГМ]

ТОВЧХОН

» ШҮҮХ

Батлан даалтад байсан Сангийн сайд асан С.Баярцогтыг цагдан хорих саналыг прокуророос Сүхбаатар дүүргийн шүүхэд ирүүлсэн. Өчигдөр уг шүүх хурал болж, түүнийг нэг сар цагдан хорих шийдвэр гаргасан байна. Шүүх хуралд С.Баярцогтыг төлөөлж хоёр өмгөөлөгч нь оролцжээ.

» ТӨЛӨВЛӨЛТ

Олон улсын шинэ нисэх буудал ашиглалтад орж буйтай холбогдуулан дагуул хотыг хөгжүүлэх талаар хэлэлцэн шийдвэр гаргав. Энэ дагуу Улаанбаатар хотыг 2040 он хүртэл хөгжүүлэх хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд Аэросити, Зуунмод хот, Майдар хотыг Улаанбаатар хотын дагуул хот гэж тусган хөгжүүлэхээр боллоо.

» ШИЙДВЭР

ЗГ Асгатын мөнгөний ордыг “Эрдэнэс Монгол” ХХК-д шилжүүлэхээр болов. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хайгуул хийж нээсэн тус ордыг Засгийн газар ойрын хугацаанд эдийн засгийн эргэлтэд оруулахаар төлөвлөжээ.

» ХӨНГӨЛӨЛТ

Томуу, томуу төст өвчтэй, тав хүртэлх насны хүүхдээ эмнэлэгт, гэрээрээ 3-5 хоног асарсан эцэг, эх, асран хамгаалагчид цалинтай чөлөө олгохыг ажил олгогч нарт даалгалаа. Өнөөдөрөөс гуравдугаар сарын 16-н хүртэл мөрдөх энэ тогтоолыг дэмжиж ажиллахыг хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийн удирдлагад мөн уриалав.

» КОМИСС

Төрийн албаны зөвлөлийн гишүүнийг сонгон шалгаруулах комиссын бүрэлдэхүүнийг Төрийн байгуулалтын байнгын хорооноос баталлаа. Тус бүрэлдэхүүнд УИХ-ын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга Э.Түвшинжаргал, Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга А.Амармэнд, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Дотоод аудитын албаны дарга С.Мөнхтөр, АТГ-ын Хяналт шалгалт, дүн шинжилгээний хэлтсийн дарга Х.Хашбаатар, УАГ-ын Санхүүгийн аудитын газрын захирал Ц.Наранчимэг, Удирдлагын академийн дэд захирал Ц.Батсүх, Жендерийн үндэсний хорооны ажлын албаны дарга Т.Энхбаяр нарыг томилов. Тэд төрийн албанд 8-38 жилийн хугацаанд ажилласан туршлагатай хүмүүс аж.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Ерөнхийлөгч 60 тэрбум, ТТ зэрэг асуудалд анхаарахыг даалгав

Төрийн тэргүүн Х.Баттулга Улсын ерөнхий прокурорын урилгаар Прокурорын байгууллагын удирдах ажилтны зөвлөгөөнд оролцон Ерөнхийлөгчийн зүгээс үүрэг өгч, иргэний хувиар хүсэлт гаргалаа.

Тэрбээр зөвлөгөөнд оролцогчдод жилийн өмнө хэлж байсан үгээ сануулж, зарим тодорхой хэргүүд шийдэгдэхгүй байгаад шүүмжлэлтэй хандав. Тухайлбал, оффшор данстай төрийн албан тушаалтнуудыг шалгах хэрэг жил тойрч, замхарч алга болсныг шүүмжлэв. Мөн Х.Баттулга Ерөнхийлөгчийн зүгээс хоёр хэрэгт прокурорын байгууллага анхаарал хандуулж өөрсдөөсөө шударга ёсыг эхлүүлэхийг “уриалав”. Эхнийх нь ЖДҮХС-тай нэр холбогдсон Ерөнхий прокурорын орлогч Б.Амгаланбаатартай холбоотой. Энэ тухай тэрбээр “Ерөнхий прокурорын орлогч Б.Амгаланбаатар ЖДҮХС-гаас хоёр жил дараалан зээл авсан нь тогтоогдсон. Өөрөө ч хүлээсэн. Асуудал гармагц би дуудаж уулзаад “Ажлаа өгөөд шалгуулсны дараа буцаад орж болно. Өргөдлөө өг” гэж хэлсэн. Харамсалтай нь тэгсэнгүй. Өнөөдөр ямар ч харинцлага хүлээлгүйгээр албан тушаалаа хашаад сууж байна. ЖДҮХС-гаас зээл авсан УИХ-



Х.Баттулга Ерөнхийлөгчийн зүгээс хоёр хэрэгт прокурорын байгууллага анхаарал хандуулж өөрсдөөсөө шударга ёсыг эхлүүлэхийг “уриалав”.

ын гишүүд орлогч прокурор Б.Амгаланбаатартай барьцаж байна гэсэн зүйл яригдаж байгаа. Прокурорын тухай хуулийн 46.5-д “Улсын ерөнхий прокурор, түүний орлогчид эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татан шалгахтай холбогдуулан бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэх асуудлыг эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгч шийдвэрлэнэ” гэсэн байна. Тэгэхээр Ерөнхий прокурор та бид хоёрт ажил байгаа гэдгийг хууль сануулж байна. Тиймээс та орлогчийнхоо асуудлыг шийдэж байж нийгэм рүү гарахгүй бол болохгүй” гэсэн юм.

Ерөнхийлөгчийн хөндсөн дараагийн асуудал нь 60 тэрбумын хэрэг болон утаанд зарцуулсан мөнгөнөөс завшсан хэрэг, Салхитын мөнгөний ордыг тойрсон маргаантай холбоотой байв. Төрийн тэргүүн 60 тэрбумын хэргийг шийдвэрлээгүйгээс УИХ-ын үйл ажиллагаа гацаанд орсон гэдгийг дурдаад, утаанд зарцуулсан мөнгийг завшсан эзэд нь тодорхой байхад шалгахгүй байгааг шүүмжилсэн. Мөн Салхитын мөнгөний ордыг завшиж, олон тэрбум төгрөгийн орлого олсон бүлэглэл тодорхой байхад хэргийг шалгахгүй байгааг гайхаж байгаагаа илэрхийлэв. Тэрбээр “Уул

уурхайг тойрсон хэрэг зөрчил их гарч байна. Та нарын хамар дор чинь хууль бус ажиллагаа дэлгэрэн цэцэглэж байхад яагаад өргөсөн тангарагаа биелүүлж ажиллахгүй байгаа юм бэ” гэв. Ерөнхийлөгч прокуроруудын зөвлөгөөнд алт, мөнгөний агууламжтай хүдрийн дээж болон дунд гарын мөнгөн аягатай ирсэн байв. Түүгээр дамжуулан төмөр зам, Сайншандын аж үйлдвэрийн парк зэрэг хөгжлийн хөтөлбөрийг зогсоож гацаасныг шүүмжилсэн. “Хэрэв тухайн үед хөгжлийн хөтөлбөрүүдийг прокурорын байгууллагын оролцоотой гацаагаагүй бол хүдрээ боловсруулж, мөнгөн аяга

хийх түүхийг эдээ гадаадаас бус эх орондоо үйлдвэрлэх байлаа” гэж тайлбарласан юм.

Харин Х.Баттулга иргэнийхээ хувиар Тавантолгойн ордыг гэрээгээр халхавчлан гаднынханд өгөх оролдлого гарсныг шалгуулах хүсэлт гаргав. Тэрбээр “Ард түмний өмчид байдаг Таван толгойн орд газрыг гэрээгээр халхавчлан 60 болон 40 жилээр сунгах нөхцөлтэйгээр үнэгүй өгөх оролдлого удаа дараа гарлаа. 2015 оны дөрөвдүгээр сард Засгийн газар ийм гэрээ байгуулах гэж байсныг тухайн үеийн УИХ-ын удирдлага болон 40 гишүүн зогсоосон юм. Тэдний нэг нь би. Мөн Ж.Эрдэнэбат Ерөнхий сайд байхдаа үүнийг дахин зүтгүүлсэн” гэсэн юм. Иргэн Х.Баттулгын эсэргүүцлийг хүлээж авсан Улсын Ерөнхий прокурор М.Энх-Амгалан хариуд нь “Прокурорын байгууллага зөвхөн хуульд захирагдаж үйл ажиллагаагаа явуулна. Хэн нэгнийг гэмт хэрэг гэж ярихаар нь хэрэгт татдаг, хэн нэгнийг буруутай байх ёстой гэхээр буруутгадаг асуудал миний үед л лав гарахгүй. Би үүнийг та нарын өмнө, Монгол Улсын Ерөнхийлөгчийн өмнө хэлэв. Хэн нэгнийг хэлмэгдүүлж чадахгүй, хэн нэгнийг харинцлагаас мултлахгүй” гэсэн юм. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗАР

Цалин, тэтгэврийг нэмлээ

Тэтгэврийн дундаж хэмжээ 372 мянган төгрөг болж өслөө

Б.Сэлэнгэ
ЗГМ

Засгийн газар ээлжит хуралдаанаараа нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр болон цэргийн алба хаасны тэтгэврийг ирэх сарын 1-нээс нэмэхээр шийдвэрлэлээ.

Ингэснээр бүрэн тэтгэврийн доод хэмжээ 310 мянга, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ 269 мянган төгрөг болж байна. 408 мянга гаруй иргэний тэтгэвэр 24-30 мянган төгрөгөөр

нэмэгдэж, дундаж тэтгэвэр 372 мянган төгрөг боллоо.

Мөн хуралдаанаар нийгмийн халамжийн тэтгэвэр 155 байсныг 174 мянган төгрөг, асаргааны тэтгэмжийг сард 76 мянган төгрөг байхаар тогтлоо.

Нийгмийн халамжийн тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй ганц бие ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй, тэжээгч нь нас барсан хагас, бүтэн өнчин хүүхэд зэрэг халамж зайлшгүй шаардлагатай 60 орчим мянган хүн авдаг.

16 хүртэлх насны, байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд нийгмийн халамжийн тэтгэвэртэй тэнцүү хэмжээгээр тусламж олгож байгаа бөгөөд үүнд 11 мянган хүүхэд хамрагдаж байна. Байнгын асаргаа шаардлагатай иргэн, хүнд нөхцөлд байгаа хүүхэд, ганц бие, харж хандах хүнгүй ахмад настан, хөгжлийн

бэрхшээлтэй иргэнийг гэр бүлдээ авч асарч байгаа 61 мянга гаруй хүн асаргааны тэтгэмж авдаг юм.

Хуралдаанаар эрүүл мэнд, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэлийг мөн шинэчлэн батлав.

Мөн төрийн албан хаагчдын цалинг найман хувиар нэмж байгаа аж. Харин эмч, багш нарын цалинг 20 хүртэл хувиар, дүүрэг, сум, хороо, багийн Засаг дарга, нийслэл, аймаг, дүүрэг, сумын Засаг даргын орлогч нарын цалинг найман хувиар нэмлээ.

Төрийн албан хаагчдын дундаж цалин 2018 оны байдлаар 804 мянган төгрөг байсан бол одоо 916 мянган төгрөг болж нэмэгдлээ. [ЗГМ]



Бидний хайрт эцэг, халамжит хань Балдангийн Гаваа 2019.01.12-ны өдөр 68 насандаа бурхан боллоо. Аав минь халамжит сайн хань, бусдын сайн анд нөхөр, нэр хүндтэй удирдан зохион байгуулагч, ажилсаг хичээнгүй нэгэн байлаа.

Балдангийн Гаваа нь 1946 онд Увс аймгийн Сагил сумын Борцоо голд Балдангийн зургаа дахь хүү болон мэндэлжээ. 1956 онд бага, дунд сургууль дүүргэж, 1966-1970 онд Санхүү эдийн засгийн техникумд үйлдвэрийн нягтлан бодогчийн ангид

ЭМГЭНЭЛ

суралцан төгсжээ. Тэрбээр 1971-1982 онд Сангийн яамны үнэт цаасны эрхлэгчээр ажиллаж байв. Ажиллаж байх хугацаандаа Монгол улсын их сургуулийн Нягтлан бодогч, эдийн засгийн оройн ангийг төгссөн юм. Сангийн яамны сайдын 11 дүгээр тоот томиллоотоор Төв аймгийн Баяндэлгэр сумын нэгдэлд чанарын албаны дарга, “Ундрэм” улсын үйлдвэрийн газрын дарга, Налайхын эрчим хүчний салбарт байцаагч ажилтнаар ажиллаж байгаад 2006 онд өндөр насны тэтгэвэртээ гарсан юм. Ажиллаж байх хугацаандаа Сангийн яамны хүндэт жууш бичиг, эрчим хүчний тэргүүний ажилтан цол тэмдгээр шагнуулж байсан.

Таны минь гэгээн дүр үр хүүхэд бидний сэтгэл зүрхэнд үргэлжид амьд сэрүүн байх болно. Тэнгэрийн оронд заларсан аав минь энх амгалан нойрсож, үр хүүхэд бидэндээ эргэн төрөх болтугай.

УМ САЙН АМГАЛАН БОЛТУГАЙ

Хань ижил, үр хүүхэд, ах дүү, төрөл төрөгсөд

Нийтлэлчийн булан

Тайландын хорт утаа Монголын хувьд цэвэр агаар л гэсэн үг



С.Батсайхан / ЗГМ©

Тайландын нөхцөл байдал Монголын хувьд “бага бохирдол” гэсэн ангилалд орно

Г.Баярсайхан
@bayarsaikhanZGM

Тайландын Ерөнхий сайд Прают Чан-Оча нийслэл Бангкок хотын иргэдэд хандан уриалга гаргасныг дэлхийн томоохон хэвлэлүүд дуу дуугаа авалцан мэдээлэв. Тус хотод агаарын чанарын индекс 182 хүрч өссөн нь Азийн хамгийн их бохирдолтой хотууд болох Шинэ Дели, Бээжин, Жакартагийн хэмжээнд хүрчээ. Тиймээс хотын иргэдийг онц шаардлагагүй бол гэрээсээ гарахгүй байх, гарсан тохиолдолд амны хаалт заавал хэрэглэхийг Ерөнхий сайд нь сануулав.

Тайланд бүс нутагтаа агаарын бохирдол ихтэй орны тоонд ордог бөгөөд барилгын ажил, автомашины утаа, үйлдвэрүүд бохирдлын эх үүсвэр болдог тухай Bloomberg мэдээлсэн юм. Нэгэнт агаарын бохирдол аюултай түвшинд хүрсэн тул Засгийн газрын зүгээс барилгын талбайг хянах, машины утааг шалгах зэрэг арга хэмжээ авахаар төлөвлөжээ.

Тайландууд ийнхүү сэхээ авч хөдлөөд эхэллээ. Харин Монголд ийм нөхцөл байдал тохиолдвол яах бол. Тийм ээ, таны бодож байгаа хариулт мөн. Манай төр засаг яах ч үгүй. Энэ байтугай гамшиг нүүрлэнхээд байхад нүдэн балай, чихэн дүлий байдаг нөхдийн хувьд 182 гэдэг үзүүлэлт юу ч биш. Өдгөө Монголд мөрдөгдөж буй стандартаар агаарын чанарын индекс 0-50 бол цэвэр, 51-100 бол хэвийн, 101-200 нь бага бохирдолтой тооцогддог. Харин 201-300 нь бохирдолтой, 301-400 бол их бохирдолтой, 401-500 бол маш их бохирдолтой гэж үздэг. Тэгээд 500-гаас дээш бол гамшигын үеийн нөхцөл байдал гэж тооцогддог. Эндээс харвал Ерөнхий сайд нь ард иргэдээ гэрээс гарахгүй байхыг сануулж буй 182 гэдэг үзүүлэлтэй Тайландын нөхцөл байдал Монголын хувьд “бага бохирдол” гэсэн ангилалд орох нь. Ер нь ихэнх тохиолдолд агаарын чанарын индекс онц аюултай хэмжээнээс хэд дахин давдаг Монгол Улсын хувьд 182 гэсэн үзүүлэлт цэвэр цэнгэг агаар мэт ойлгогдох болжээ. Тайланд болон Монголын нөхцөл байдал тэнгэр, газар шиг ялгаатай байгаа биз.

Уг нь дэлхийн ихэнх оронд мөрддөг стандартаар бол индекс 151-200-д хүрвэл агаар

бохирдолтой, 201-300-г маш их бохирдолтой, 300-гаас дээш гарвал гамшигын хэмжээний үзүүлэлт гэж тооцдог. Харин манай стандарт олон улсын жишгээс яагаад зөрөөд байна вэ. Монгол хүн утаанд тэсвэртэй гэж үзсэнийх үү. Эсвэл бид хүний анатомиос өөр бүтэцтэй, мутацид орсон ард түмэн гэж үү. Энэ талаар УЦОШГ-ын мэргэжилтэн С.Энхмаагаас тодруулахад “Агаарын чанарыг тооцох аргачлал, мөрдөх стандарт улс орон бүрт өөр. Мэдээж Улаанбаатарын утааг Токио, Бангкокийн нөхцөл байдалтай харьцуулах аргагүй. Яагаад гэвэл, утааны эх үүсвэр нь өөр өөр. Манай улсын хувьд АНУ, Хятадад мөрддөг арга, стандартаар агаарын чанараа хэмжиж байна. Монголд хамгийн тохиромжтой гэж үзсэний үндсэн дээр ийм шийдвэр гаргасан байх” гэсэн юм.

Америкийнх ч бай, Хятадынх ч бай, бид ямартай ч нэлээд зөөлөн стандарт мөрддөг байх нь. Улс орнууд аюулын харанга дэлдэж, ард иргэдээ сэрэмжлүүлээд буй үзүүлэлт бидний хувьд санаа зовох хэмжээний биш гэсэн үг. За яахав, улс орон бүрийн мөрдөх стандарт өөр гэдгээр энэ асуудлыг хаацайлаад өнгөрлөө гэж бодъё. Гэтэл бидний мөрдөөд буй өнөөх зөөлөн стандартаас нь хэд дахин давсан нөхцөл

үүсчихээд байхад манай дарга нар яагаад чимээгүй сууна вэ. Ард иргэддээ уриалж, сэрэмжлүүлэх сэтгэлтэй дарганцар алга уу, цаана чинь.

Манай улс 2014 оноос хойш агаарын чанараа хэмжих болсон. Энэ үеэс хойш хорт утаа жил бүр нэмэгдсээр иржээ. Агаар.mn сайт дахь зарим тоон үзүүлэлтэд анхаарлаа хандуулья. 2018 оны 12 дугаар сарын 17-23-ны өдрүүдэд агаар дахь PM 2.5 тоосонцрын хэмжээ зөвшөөрөгдөх стандартаас 13.9 дахин давжээ. Энэ өдрүүдэд 100 айл, Баруун дөрвөн зам орчимд агаарын чанарын индекс мянган босго давсан байв. 500-гаас хэтэрвэл гамшиг нүүрлэлээ гэж үздэг байтал гамшигын үзүүлэлтээс хоёр дахин давсан. Харин хамгийн сүүлийн мэдээллээр буюу нэгдүгээр сарын 7-13-ны хооронд хамгийн их хөнөөлтэй, хамгийн нарийн ширхэгтэй PM 2.5 тоосонцор зөвшөөрөгдөх стандартаас 15 дахин давсан байна. Энэ үед 100 айл, Баянхошуу, Баруун дөрвөн зам, 13-р хорооллын орчимд агаарын чанарын индекс 1400-1500-гийн хооронд хэлбэлзэж байлаа. Бид ийм л нөхцөлд ажиллаж, амьдарч байгаа нь эмгэнэл биш гэж үү. Гэтэл асуудлыг хариуцсан сайд, дарга нар юу ч болоогүй мэт дулий дүмбэ оргисоор. Тэр ч байтугай Байгаль орчны

өмнөх сайд нь “Энэ бол гамшиг зарлах хэмжээний аюул биш” гэж мэдэгдэн ард түмнийг доромжилсон шигээ сууж байв.

● **Агаарын чанарыг тооцдог манай стандарт олон улсын жишгээс яагаад зөрөөд байна вэ. Монгол хүн утаанд тэсвэртэй гэж үзсэнийх үү.**

● **Индекс 500-гаас хэтэрвэл гамшиг нүүрлэлээ гэж үздэг байтал гамшигын үзүүлэлтээс гурав дахин давжээ.**

● **Зөвшөөрөгдөх стандартаас 15 дахин давсан, гамшигын хэмжээнээс гурав дахин ихэссэн агаараар амьсгалж буй хүмүүс яаж ч эрүүл байх билээ.**

Манай хүний үнэргүй дарга нар аюулыг аюул биш гэж харагдуулахыг хичээж, статистик үзүүлэлтүүдийг дарахыг оролдох зуур агаарын бохирдлоос үүдэлтэй үй түмэн асуудал ард олныг нэрвээд дууслаа. Дүүргийн эмнэлгүүдэд хэдэн зуун ор нэмж тавиад байгаа хэрнээ багталцахгүй байгаа тул эцэг, эхчүүд хонгилд эвхдэг ор тавиад хүүхдээ асарч байна. Ганц өдөрт 200 гаруй хүүхэд шинээр хэвтэн эмчлүүлж байгаа талаар ЭМЯ-ны хэлтсийн дарга нь ярилаа. Ханиаданд сайн гэсэн эм нь олдохгүйгээс болж социал орчинд нэгнээсээ эм гуйх өрөвдөлтэй дүр зураг улам ихсэв. Яг ингэж ядарч зовсон үед нь эм, тарианы үнэ дунджаар 11.4 хувиар өссөн болохыг Үндэсний статистикийн хорооны мэдээлэл баталлаа. Энэ хэрээр иргэдийн халаасан дахь цөөн хэдэн төгрөг улам нимгэрсээр байна. Ханиад томууны дэгдэлт ихдсэн шалтгаанаар Дорнод, Төв аймагт хорио тогтоож, сургууль, цэцэрлэг, үйлчилгээний газруудыг хаах шийдвэрийг салбарын яам нь гаргав. Энэ бүгд эцэстээ утаа гэгч ганц л зүйлтэй холбогдож байгаа нь хэнд ч илэрхий. Зөвшөөрөгдөх стандартаас 15 дахин давсан, гамшигын хэмжээнээс гурав дахин ихэссэн агаараар амьсгалж буй хүмүүс яаж ч эрүүл байх билээ.

Утаа өтгөрсөн хүйтний улиралд

хатгаагаар нас барсан хүүхдүүдээс 12.5 дахин олон хүүхэд эхийнхээ хэвлийд хүн болж чадалгүй буцаг талаар манай сонин өмнө нь бичсэн. Бүр тодруулбал, өсөлтгүй жирэмслэлт манай улсад жилд 5000 орчим бүртгэгдэх болов. Тиймээс агаарын бохирдол ихтэй 11-1 дүгээр сард жирэмслэхгүй байхыг эмч нар анхааруулж байна. Харин манай дарга нар болохоор өсөлтгүй жирэмслэлт, эндсэн ураг, өвчилсөн хүүхдээ тоолж суухаас хэтэрсэнгүй. Гэхдээ “бид бүгдийн төлөө” албан тушаал, сандал ширээ булаалдан тэмцэлдэх ажлаа бол сайн хийж байгаа шүү.

Одоо бид яах ёстой юм бэ. Лав л энэ төр засаг утааг арилгаж, биднийг сайн сайхан амьдрулна гэсэн гэнэн үлгэрт итгэд хэрэггүй. Гэхдээ ядаж агаарын бохирдлыг тооцдог аргачлалаа Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас гаргасан стандартад нийцүүлж болдоггүй юм уу. Ингэвэл бид ядаж л бусад улс оронтой өөрсдийгөө харьцуулах боломж бүрдэнэ. Мөн асуудлыг хариуцсан сайд, дарга нар бодит үнэнийг хүлээн зөвшөөрч, ард иргэддээ анхааруулга сануулга өгч, гамшигын үеийн нөхцөл байдалд ажиллаж эхэлмээр байна. Гамшиг нүүрлэсэн гэдгийг мянга нуугаад нэмэргүй шүү дээ, нүдэн дээр илхэн байхад. [ЗГМ]

С.ЦОГТБАЯР ЗУРЖ БАЙНА



Нийгэм

Халдвартай гахайн мах идсэн хүн мялзан өвчин тусахгүй

◀1

Тиймээс энэ хоригийн улмаас алдаж буй ашиг, орлого нь тэр хэрээр нэмэгдэж буй.

Уг нь бүтэн жилийн өмнөөс олон улсын эрүүл мэндийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд БНХАУ-д гахайн мялзан өвчин дэгдэх магадлалтайг анхааруулж байсан. Гэвч үйлдвэрлэгчид, манай албаныхан үүнээс урьтаж арга хэмжээ аваагүй учраас ийнхүү бизнесийнхэн алдагдал хүлээж байна. Энэ талаар Мал эмнэлгийн ерөнхий газрын Мал эмнэлгийн эрүүл ахуй, баталгаажуулалтын газрын дарга Б.Батсүх “Энэ өвчин урд хөршид гарсан болохоор манай улсад бүртгэгдэх магадлал өндөр байсан учир холбогдох байгууллагуудад сэрэмжлүүлэг хүргүүлсэн” хэмээн тайлбарлав.

Африкийн гахайн мялзан өвчин Монгол Улсад анх удаа гарч байгаа аж. Өмнө нь манай улсад гахайн сонгомол мялзан өвчин дэгдэж байсан. Харин энэ удаагийнх өмнө нь гарч байгаагүй шинэ төрлийнх юм байна. Африкийн гахайн мялзан өвчний халдвар шууд хавьтлаар болон түүхий гахайн мах, дутуу болгосон гахайн махаар дамждаг аж. Үүгээр гахай өвчилбөл төрөлдөө асар их хор хөнөөлтэй. Нэгэнт халдвар авсан тохиолдолд зориудаар устгахаас өөр аргагүй болдог байна. Гэхдээ таван хошуу малд халдахгүй, хүнд ямар нэгэн хор хөнөөл байхгүй. Гахайнаас гахайнд, хүнээс гахайнд халдварладаг. Энэ өвчнөөр зэрлэг гахай болон гэрийн тэжээвэр гахай л өвчилнө. Харин уг өвчнийг хүн хувцас, эд хэрэглэлээр тээвэрлэдэг байна. Тодруулбал, гахай маллагч хүний хувцас, тоног хэрэгслээр дамжин гахайн дунд халдвар үүсгэдэг. Тиймээс халдвартай гахайн мах идсэн хүн мялзан өвчин тусахгүй, ямар нэгэн сөрөг нөлөөгүй байх магадлал өндөр. Ийм байхад дэлгүүрийн лангуун дээрх гахайн мах, махан бүтээгдэхүүний борлуулалтыг хориглох нь хэр зөв арга хэмжээ вэ гэдгийг үйлдвэрлэгчид асууж байлаа. Нэгэн үйлдвэрлэгч



Бүтэн жилийн өмнөөс олон улсын эрүүл мэндийн байгууллагууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүд БНХАУ-д гахайн мялзан өвчин дэгдэх магадлалтайг анхааруулж байсан.

BVM©

Төр хойрго хандсанаас бизнес эрхлэгчид хохиров

“Хилээр оруулж ирсэн гахайн мах, өөх халдвар тараахгүй юм байна гэж мэргэжлийнхний ярианаас ойлгосон. Гэтэл яг борлуулалтын ид үед хориглох нь ямар учиртай юм бол гээд гайхаж байна” хэмээн ярьсан юм.

Африкийн гахайн мялзан өвчин Монгол Улсад анх удаа гарсан

Өчигдрийн байдлаар уг өвчин Булган, Дундговь, Төв, Орхон аймгийн таван суманд бүртгэгдсэн бөгөөд нийт 579 гахайг зориудаар устгажээ. Уг

өвчний эсрэг вакцин байхгүй учраас урьдчилан сэргийлэх био арга хэмжээг хэрэгжүүлэхээс өөр аргагүй. Улсын хэмжээнд 31800 гаруй гахайтай, 17000 нь нийслэлд байдаг. Тодруулбал, Баян-Өлгий аймгаас бусад аймгууд тодорхой хэмжээний гахайтай. Тиймээс энэ өвчний тархалтыг нэмэгдүүлэхгүйн тулд тандалт судалгаа хийж, цаашид ямар арга хэмжээ авах талаар МХЕГ, Мал эмнэлгийн ерөнхий газар хамтран ажиллаж эхэлсэн байна. Нийслэлийн хэмжээнд 23 ажлын хэсэг гарч ажиллаж байгаа бөгөөд гахайн мах, махан бүтээгдэхүүн худалдан борлуулдаг аж ахуйн нэгжүүдэд хяналт шалгалт хийж байгаа аж. “Уг ажлын хэсэг хорио тогтоохоос өмнө орж ирсэн болон агуулахад байгаа гахайн махны гарал үүслийг тодорхойлж,

шаардлагатай гэж үзсэн тохиолдолд бүтээгдэхүүнээс дээж авч, шинжлүүлж байгаа. Шинжилгээний хариу эерэг гарсан тохиолдолд худалдан борлуулах боломжтой” хэмээн МХЕГ-ын Хөдөө аж ахуй, хяналтын хэлтсийн дарга Д.Батжаргал ярилаа. Африкийн гахайн мялзан өвчин хаанаас, юунаас болж гарсныг тогтоохоор

Мал эмнэлгийн ерөнхий газраар ахлуулсан ажлын хэсэг ажиллаж эхэлжээ. Харин үйлдвэрлэгчид гахайн махан бүтээгдэхүүнээр халдвар дамжихгүй байхад ийм хорио тогтоох шаардлага байсан эсэхэд тодорхой хариулт өгөхийг шаардаж буй. Түүнчлэн, бүтэн жилийн өмнө урд хөршид гахайн мялзан өвчин дэгдэх нь тодорхой болсон байхад

дорвитой арга хэмжээ аваагүй, албан бичиг хүргэх төдийнхээр аргацааж, хойрго хандсан нь үйлдвэрлэгчдийг их хэмжээний алдагдалд хүргэлээ хэмээн шүүмжилж байна. Гэхдээ бизнес эрхлэгчид Цагаан сарын оргил үеийг алдалгүйгээр бүтээгдэхүүнийхээ нэр төрлийг олшруулах зэргээр алдагдлаа нөхөхөөр төлөвлөж эхэлжээ. [ЗГМ]

ЗГМ: ТОДРУУЛГА

Р.Сансармаа: Гэнэтийн шийдвэр хиам үйлдвэрлэгчдэд цохилт болсон

П.Батбөх
ЗГМ



Улсын онцгой комиссоос гахайн мах, өөхний орцтой бүтээгдэхүүний худалдааг зогсоох гэнэтийн шийдвэр мах, хиаман бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, бизнесийнхэнд хэрхэн нөлөөлж буй талаар “Траст трейд” ХХК-ийн гүйцэтгэх захирал Р.Сансармаагаас тодрууллаа.

–Улсын онцгой комисс шийдвэр гаргасан нь мах, хиаман бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд хэр нөлөөлж байна вэ?

–Нэгэнт олон улсад онцгой байдал зарлах өвчин дэгдэж Улсын онцгой комиссын шийдвэр гарсан учраас биелүүлэхээс аргагүй. Мэргэжлийн хяналтын байгууллагаас манай компанийн гахайн төрлийн 20 гаруй тонн түүхий эдийг лацадсан. Тэдний зүгээс “Мал эмнэлгийн ерөнхий газарт шинжилгээг нь явуулсан байгаа. Хариу нь эерэг гарвал лацыг авч үйлдвэрлэл, борлуулалтыг зөвшөөрнө” гэсэн байдалтай байгаа.

–Тэгэхээр танай энэ төрлийн бүтээгдэхүүний борлуулалт зогссон байгаа гэсэн үг үү?

–Гахайн махны төрлийн

бүтээгдэхүүний үйлдвэрлэлт зогссон. Харин үйлдвэрлэсэн байсан бүтээгдэхүүнээ түгээж байгаа. Шинжилгээний хариу гарахгүй удах юм уу, сөрөг гарсан тохиолдолд мэдээж худалдаа ч гэсэн зогсоно. Үхэр, хонины махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа хэвийн байгаа. Ер нь өнгөрсөн 12 сард гахайн өөхийг хиаман бүтээгдэхүүнд хэрэглэхийг хязгаарласан. 2014 оноос манай импортлогчид БНХАУ-аас гахайн өөх импортлож байгаад өвчин гарсан гэдгээр Польшоос авдаг болсон. Гэвч өнгөрсөн оны 12 дугаар сард ОХУ-ын Ерөнхийлөгчийн зарлиг гарч тус улсаар өөхийг дамжин өнгөрөөхийг хориглосноор нийлүүлэлт зогссон. Манайх гахайн өөхийг сүүлээр орлуулж эхэлсэн учраас одоогоор заавал гахайн өөх орлуулах талд дутагдалд ороод байгаа юм алга.

–Цагаан сарын өмнө гахайн махан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хязгаарласан нь борлуулалтын орлогод хэр нөлөөлж вэ?

–Цагаан сарын оргил үеийн борлуулалт энгийн улирлынхаас бараг гурав дахин илүү байдаг. Тэр хэрээр байгууллагын орлогод нөлөөлж байгаа. Манай компанийн хувьд гэхэд жилдээ 12 тэрбум төгрөгийн борлуулалт хийдгээс цагаан сарын үеэр 1.9 тэрбум төгрөг буюу жилийн орлогын бараг зургааны нэг хувийг олдог. Гэхдээ бид хэдийгээр ашиг олох зорилготой боловч иргэд, үйлчлүүлэгчдийнхээ эрүүл

мэнд, аюулгүй байдалд илүү ач холбогдол өгч ийм эрсдэлийг үүрэхээс аргагүй болж байна л даа. Өнгөрсөн шинэ жилээр хиамны борлуулалт өмнөх оныхоос 30 хувиар буурсан. Энэ цагаан сараар бүр 50 хувьд хүрнэ гэж тооцоолж байна. Тиймээс бид хиамыг орлож ширээ чимэглэх хонины шарсан гуя, үхрийн хэл зэргийг түлхүү үйлдвэрлэхээр төлөвлөж байгаа.

–Төрийн холбогдох байгууллагууд урьдчилан сэргийлэх арга хэмжээг аваагүйгээс бизнес эрхлэгчид эрсдэлд орлоо гэдэгтэй санал нийлэх үү?

–Жилийн өмнөөс л БНХАУ-д энэ төрлийн өвчин гарч, эрсдэл үүсэх магадлалтайг мэдсээр байж урьдчилан сэргийлэх арга хэмжээ аваагүй нь бизнес эрхлэгчдийг хохироосон хариуцлагагүй явдал боллоо. Ер нь манай улсын аль ч салбарт системтэй бодлого алга. Зөвхөн махны импорт гэлтгүй бүх салбарт ийм зүйл ажиглагддаг. Бид гомдоллоод ч нэмэр алга. 2018 оны эхнээс л Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль хэрэгжиж эхэлсэн ч урьдчилан сэргийлэлт, зохион байгуулалт сайжирсан зүйл бидэнд мэдрэгдэхгүй л байна. Үүнээс болж онцгой байдал зарлахад хүргэлээ. Энэ нь махан бүтээгдэхүүн тэр дундаа хиам үйлдвэрлэгчдэд цохилт боллоо.

–Хиаман бүтээгдэхүүний үнэ нэмэгдэх үү?

–Үнэ нэмэгдэх нь тодорхой. Тэр хэрээр иргэдийн худалдан авалт багасах энэ төрлийн бизнес эрхлэгчдэд хүндээр тусах байх. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдөр

Тендер шалгаруулалтын нэр: “Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших зорилтот бүлгийн иргэдийг сайжруулсан түлшээр хангах”

Тендер шалгаруулалтын дугаар: НХААГ-19/005

Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас эрх бүхий тендер оролцогчдоос “Агаарын чанарыг сайжруулах бүсэд орших зорилтот бүлгийн иргэдийг сайжруулсан түлшээр хангах” нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү барааны тендер шалгаруулалт нь Цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 50,000 (тавин мянга) төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн 45 хоногийн дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

● **Борлуулалтын хэмжээ:** Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын аль нэг жилийн борлуулалтын орлого нь төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.

● **Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 3 жил буюу 2016, 2017, 2018 онуудын аль нэг жилд төсөвт өртгийн 50 хувиас багагүй ижил төстэй ажил хийсэн байна.

● **Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Төсөвт өртгийн 50 хувиас багагүй байна.

● **Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо:** Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 он

● **Тендерийн баталгааны үнийн дүн:** 1,803,690 /нэг сая найман зуун гурван мянга зургаан зуун ер/ төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Цахим тендер оролцогч цахим баталгаа гаргах эрх бүхий арилжааны банкаар цахим тендерийн баталгаа гаргуулна.

Хүчинтэй байх хугацаа: 2019 оны 05 дугаар сарын 02-ны өдрийг дуустал хүчинтэй байна. Тендерийг 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 10:00 цагаас өмнө системд ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг 2019 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн 10:30 цагт Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын 1012 тоот өрөөнд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаагаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Бага тойруу-15, Самбуугийн гудамж, Нийслэлийн Засаг захиргааны 4 дүгээр байр, 10 дугаар давхар, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газар, Утас: 75757810

Цахим хаяг: www.tender.gov.mn, www.ub-procurement.mn

ЗГМ: Сэдэв

ДАВОС-2019

Урьдчилан сэргийлэхэд зарцуулсан \$1 хохирлыг долоо дахин буруулдаг

“Азид буурай хөгжилтэй орнууд их тул гамшигт эмзэг. Тийм учраас дэлхий дахин гамшгаас хэрхэн сэргийлэх, яаж хохирол багатай даван туулах тухай л ярьж байна” хэмээн манай гамшгийн асуудал хариуцсан албаны эх сурвалж онцолсон юм. Монголын хувьд уур амьсгалын өөрчлөлт хамгийн эртэй явагдаж байгаа орон. Бид өндөр хөгжилтэй орнууд шиг нүүрснээс татгалзаж, эрчим хүчээ ногооруулах замаар агаарын температурыг цельсийн 1.5 хэмээр бууруулна гэх амбийцтай бодлого хэрэгжүүлэх боломж, бололцоо байхгүй. Хамгийн гол нь уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох нь чухал. Үүний тулд гамшгийн эрсдэлийг бууруулахад л бодлогоо чиглүүлэх ёстойг гамшгийн мэргэжилтнүүд хэлж байна.



Гамшгийн хохирол барагдуулахад зарцуулдаг хөрөнгө жилийн жилд нэмэгдэж буй нь бид гамшгийн эрсдэлийг шилжүүлж, менежмент хийж чадахгүй байна гэсэн үг.

Б.Хасуй / ЗГМ ©

Гамшгийн хохирол багатай туулах бодит шийдэл хэрэгтэй


Сүүлийн жилүүдэд хур тунадасны хэмжээ өвөлдөө ихэсж, зундаа багасах буйг мэргэжилтнүүд онцлох болсон. Өвөл цас их орох нь яалт ч үгүй уур амьсгалын өөрчлөлтийн үр дүн аж. Тиймээс ч НҮБ-аас 2001 онд зудыг байгалийн гамшигт албан ёсоор бүртгэсэн. Гэтэл бид хамгийн их тохиолддог зудыг хамгийн хохирол багатай даван туулах арга замаа одоо хэр нь олоогүй. Тун саяхны жишээ гэхэд, 2016-2017 онд Монголд зудын улмаас нийт малын зургаан хувь нь үрэгдэж, 157 мянган хүн өртсөн. Үүнд 2500 жирэмсэн эх, таваас доош насны 26 мянган хүүхэд, ахмад настан 13 мянга байсан байна. Зудын улмаас махны болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнэ 10 хувиар өсөж, Монгол Улс олон улсын хүмүүнлэгийн байгууллагаас 6.6 сая ам.долларын хүмүүнлэгийн тусламж авсныг Ази, Номхон далайн гамшгийн тайланд дурджээ. Уг нь гамшгийн эрсдэлийг шилжүүлэх олон арга бий. Тухайлбал, зудын эрсдэлийг бууруулахын тулд малын индексжүүлсэн даатгал маш үр дүнтэй байдаг аж. Эдийн засгийн хувьд ч үр дүнтэй шийдэл. Гэвч жилийн жилд л зуданд малаа алдагсад төв суурин руу нүүдэллэж, ажилгүйдэл, ядуурлын тоог улам нэмсээр.

2018 онд гамшиг, ослын үед авах арга хэмжээ, хохирол барагдуулахад Засгийн газраас гаргасан нөөц хөрөнгө 15 тэрбум төгрөгт хүрсэн. Албаныхны хэлж буйгаар энэ хэмжээ жилийн жилд нэмэгдэж буй нь бид гамшгийн эрсдэлийг шилжүүлж, менежмент хийж чадахгүй байгаагийн илрэл аж. Уг нь эрсдэлээс сэргийлж чадвал энэ мөнгийг долоо дахин хэмнэх боломж бий. Олон улсад гамшгийн дараа учирсан долоон ам.доллар бүр урьдчилан сэргийлэхэд зарцуулсан нэг ам.доллартай тэнцдэг гэсэн судалгаа байдаг. Тиймээс дээрх хэмжээний хөрөнгийг жилийн жилд барилга байгууламжаа хүчитгэх, эрчим хүчний шонгийн суурийг сайжруулах, замаа засаж, үерийн далан, шуудуу баривал чухам хэрэгтэй баймаар. Гэтэл 2018 онд нийслэлд нэг ч үерийн далан, суваг нэмж барьсангүй. 1966 оны үерийн дараа барьсан далан, сувгуудын 80 хувь нь эвдэрсэн нь 2015 онд Улаанбаатар хотын гамшгийн эрсдэлийн үнэлгээгээр тодорхой болжээ. Тиймээс үер болвол Сонгинохайрхан дүүрэгт л гэхэд 100 хүний ес нь, Чингэлтэй дүүрэгт 100 хүн тутмын дөрөв нь амиа алдах эрсдэлд амьдарч байна.

Тиймээс ядаж л олон нийтийн сүлжээг урьдчилан сэргийлэхэд идэвхтэй ашиглах бүс нутгийн хандлагатай хөл нийлүүлмээр байна. Индонезид AtmaGo аппликейшний тусламжтай үерээс сэргийлэх анхааруулга явуулснаар нэг өрхөд учрах хохирлыг жилд 324 ам.доллараар буулгаж чадсан байна. Харамсалтай нь, манайд хүмүүсийн нас, онцлогт нь тохирсон контентоор урьдчилан сэргийлэх ажил хийж чадахгүй байгааг ОБЕГ-ын Гамшгийн эрсдэлийн удирдах газрын дарга, дэд хурандаа Д.Баасансүрэн хэллээ. Мөн салбар дундын хамтын ажиллагаа хамгийн их хэрэгтэй байгаа ч төрийн ихэнх байгууллага санхүүжилт байхгүй гэдэг шалтгаанаар хойш суусаар байна.

Байгалийн гамшиг, түүнийг

Монгол Улсын хэмжээнд Байгалийн аюулт үзэгдэл, ослын улмаас үүссэн хохирол			
	2016	2017	2018
Аюулт үзэгдэл, ослын тоо	4381	4194	4373
Эндсэн хүний тоо	230	203	208
Бэртсэн хүний тоо	61	62	67
Шууд хохирол /тэрбум /	43.1	96.7	81.9



даван туулах чадвар муу байгаа нь Монголд төдийгүй бус нутагт ч хөгжлийн хурдыг хойш чангааж буй тул энэ асуудалд шийдэл

олохоор өнөө жил Давосын эдийн засгийн чуулганы эрхэм зочид ухаанаа уралдуулж, шинэ санаагаа хуваалцах аж.

ЗГМ: ТОДРУУЛГА

Д.БААСАНСҮРЭН: ГАМШГИЙН ЭРСДЭЛИЙГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛ БАЙГУУЛСАН



ОБЕГ-ын Гамшгийн эрсдэлийн удирдах газрын дарга, дэд хурандаа Д.Баасансүрэнгээс зарим асуудалд харуулт авлаа.

-Гамшгаас сэргийлэхэд ямар бодлого хэрэгжүүлж байна вэ?

-Саяхан Гамшгийн эрсдэлийг бууруулах үндэсний зөвлөл байгууллаа. Энэ зөвлөлийг Ерөнхий сайд ахалж, бүх яам, агентлагийн удирдлагаас гадна хувийн хэвшил, ТББ-ын төлөөлөл оролцож байгаа. Улсын онцгой комиссоос ялгаатай нь гамшиг, үймээн самуун, гоц халдварт үйлдэх хөрөнгө оруулалтыг шийдэх зорилготой. Гамшгаас сэргийлэх, даван туулахад зөвхөн Засгийн газрын нөөц сангаас бус тухайн орон нутгийн засаг даргын нөөц хөрөнгийн 30 хувиас багагүй хэсгийг зарцуулахаар болсон.

-Хүн амын хэчнээн хувийг гамшигт эмзэг хэсэг эзэлж байгаа вэ?

-Хүн амын мэдээллийн нэгдсэн сангаас тодорхой тоо гарах байх.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон хүүхэд, эмэгтэйчүүдээ тооцход нийт хүн амын 20-30 хувь нь гамшигт эмзэг хэсэг гэж үздэг. Амьжиргааны түвшин доогуур болон гэр хорооллын өрхүүдийг тооцвол эмзэг хэсэг бүр нэмэгдэнэ. Ер нь Ази, Номхон далайн бүсэд гамшигт өртөгсдийн 70 гаруй хувь нь бага орлоготой өрх байдаг.

-Нийслэлийн хэмжээнд гамшгийн эрсдэлийг тооцсон юм байна. 1966 оных шиг үер нийслэлд буувал нөхцөл байдал ямар болох талаар танд төсөөлөгдөж байна уу?

-Тэр үеийнх шиг байтугай өнгөрсөн зун 30 минут хүрэхгүй хугацаанд бороо ороход л хот тэр чигтээ үерт автаж, гэр хорооллын өрхүүд сүйдэж, хүний амь үрэгдсэн. 1966 оноос хойш хот газар нутгаараа гурав дахин тэлж, гэр хороолол хэдэн арав дахин томорч, нягтрал нэмэгдсэн. Үерийн аюулын зургаас харахад хэдхэн газар л үер болдог. Эдгээр газартаа л арга хэмжээ аваад, төсөвлөлтөө анхаарахад эрсдэл буурна. Манайх төсөв мөнгө хуваарилдаг, захиран зарцуулдаг байгууллага биш учраас бид холбогдох газруудад зөвлөмж өгч, шаардлага хүргүүлэхээс хэтэрэггүй. Гамшгаас сэргийлнэ гэдэг байгууллага, хүн бүр оролцож байж үр дүнтэй болно. Тиймээс байгууллагууд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх ёстой. [ЗГМ]

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019.01.17

Тендер шалгаруулалтын нэр: **Гэмтэл согог судлалын үндэсний төвийн 2019 онд худалдан авах эм, эмнэлэгийн хэрэгсэл, лабораторын урвалж, цус, цусан бүтээгдэхүүн худалдан авах нээлттэй тендер**

Тендер шалгаруулалтын дугаар: **№ГССҮТ/2019002**

[Гэмтэл согог судлалын үндэсний төв] эрх бүхий тендер оролцогчдоос [2019 онд худалдан авах эм, эмнэлэгийн хэрэгсэл, лабораторын урвалж, цус, цусан бүтээгдэхүүн]-ын нээлттэй сонгон шалгаруулах цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Борлуулалтын хэмжээ: **Сүүлийн 5 жилийн борлуулалтын хэмжээ 150,0 сая төгрөгөөс багагүй байх**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Тендерт санал болгож буй үнийн днгийн 50 хувиас багагүй**

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **2 жил**

Сүүлийн гурван жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: **100,0 сая төгрөгөөс багагүй байх**

Тусгай зөвшөөрөл ирүүлнэ.

Тендерийн хамт **tender.gov.mn** сайтад заасантай тэнцэх төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй. Дотоодын давуу эрх тооцно.

www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээллийг болон тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50000** /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендерийн материалыг цахим системээр **2019 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн 12 цаг 00 минут**аас өмнө **www.tender.gov.mn** хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй иргэн болон хуулийн этгээдийг байлцуулан **2018 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн 12 цаг 30 минутад** нээнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг **www.tender.gov.mn** сайтаас авна уу.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

УБХ, БГД 7 дугаар хороо Жалханз хутагт Дамдинбазарын гудамж
Гэмтэл согог судлалын үндэсний төв Эдийн засаг санхүү бүртгэлийн алба
Утас: 70180140, 97116879

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо : 2019.01.17

Тендер шалгаруулалтын нэр: **Өндөр өртөгт тусламж үйлчилгээнд шаардлагатай имплант, протез, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах нээлттэй тендер**

Тендер шалгаруулалтын дугаар: **№ ГССҮТ/2019/001**

[Гэмтэл согог судлалын үндэсний төв] эрх бүхий тендер оролцогчдоос [Өндөр өртөгт тусламж үйлчилгээнд шаардлагатай имплант, протез, эмнэлгийн хэрэгсэл худалдан авах нээлттэй тендер]-ын нээлттэй сонгон шалгаруулах цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Тендер оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд: Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: **сүүлийн 2 жил /2017, 2018 он/** Борлуулалтын хэмжээ: **2017, 2018 онуудын аль нэг жилийнх нь борлуулалтын орлогын хэмжээ нь санал болгож буй үнийн дүнгийн 50 хувиас багагүй байх.**

Захиалагчийн санал болгосон тухайн багцын барааг нийлүүлж байсан талаархи туршлага болон ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: **Сүүлийн 2 жил буюу 2017, 2018 оны аль нэг жилд санал болгож буй үнийн дүнгийн 25 хувийс багагүй байх.**

Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо **/2 жил/**

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: **Санал болгож буй үнийн дүнгийн ажлын 50 хувиас багагүй байх.**

Тендерийн хамт **158,064,522** төгрөгийн үнийн дүнтэй цахим тендерийн баталгаа ирүүлнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй. Дотоодын давуу эрх тооцно.

www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээллийг болон тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендер оролцогч нь тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө **50000** /тавин мянга/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендерийн материалыг цахим системээр **2019 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн 10 цаг 00 минут**аас өмнө **www.tender.gov.mn** хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй иргэн болон хуулийн этгээдийг байлцуулан **2018 оны 02 дугаар сарын 18-ний өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ. Дэлгэрэнгүй мэдээллийг **www.tender.gov.mn** сайтаас авна уу.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

УБХ, БГД 7 дугаар хороо Жалханз хутагт Дамдинбазарын гудамж
Гэмтэл согог судлалын үндэсний төв Эдийн засаг санхүү бүртгэлийн алба
Утас: 70050130, 99995187

ZGM DAILY

Citizens' Representative Council meets after several delays

Self-nominated candidate wins against MPP board-nomination.

TDBM cooperates with Crowdfunder for crowdfunding in Japan

This will allow the bank to raise MNT-denominated credit from Japan in a crowdfunding.

Mongol Basalt Stock price rises 13.9 percent since January 1

The company's sales revenue grew by 85 percent last year.

Chinese coal consultant firm expect Ovoot coking coal price to rise

The outlook is based on the increasing demand of coking coal in Haibei Prefecture of China.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Cabinet raises the salaries of public sector by 8 percent, medical workers and teachers by 20 percent. Including the salary raise in 2018, the medical workers and teachers' salary has been increased by 30 percent. The decision is effective starting from January 1, 2019.

Pension to increase by 7.6 percent next month.

International Trade Centre team pays a visit to Mongolia to monitor the preparation of the Trade and Investment Roadmap of Mongolia and its implementation.

Minister of Labor and Social Protection Chinzorig Sodnom meets the UNFPA Mongolia Country Representative Naomi Kitahara in connection with the expiry of her term of office and handed over a Foremost Employee for Social Protection award in recognition of her valuable contribution to youth development of Mongolia.

ECONOMY

According to the National Statistics Office, 50.4 percent of about 170,000 private entities listed at the registry database is actively operating in Mongolia.

In 2018, the Customs Authority generated MNT 2.73 trillion to the State Budget.

Top 20 Index falls 0.02 percent, to 21,489.22 points. MSE A Index increases 0.08 percent, to 10,001.18 points. MSE B Index reduces 0.04 percent, 8,689.77 points. Market cap stands at MNT 2.49 trillion.

SOCIETY

Within the frame of the 2040 General Plan for Ulaanbaatar Development, the Cabinet selects three cities, namely Aerocity, Zuunmod and Mairad as satellite cities.

"Humans in Sweden" photo gallery opens at the Mongolian Theatre Museum.

New mayor faces challenge to contain swine flu amid anger over pollution

Munkhchuluun Samdannyam elected as the Mayor of Ulaanbaatar city

Tugsbilig.B
@tugsbiligZGM

Yesterday, the Citizens' Representative Council of the Capital City (CRCC) elected the next Mayor of Ulaanbaatar city after finally rising from a political deadlock. Munkhchuluun Samdannyam, the newly elected Mayor of Ulaanbaatar city, now faces a burdening challenge of tackling the swine flu outbreak.

Mr. Munkhchuluun had a tight run against Amarsaikhan Sainbuyan, former Head of CRCC as the poll ended in a tie and the re-poll was in favor of Munkhchuluun, who self-nominated himself at the meeting, with 24 to 43 votes. As for Amarsaikhan, the board of Mongolian People's Party nominated him on December 28, but the election had to be postponed because the CRCC could not form the quorum.

After the appointment of Mr. Munkhchuluun, the CRCC put



Khasui.B / ZGM©

"Swine flu and influenza outbreak issues" as the next item on the order list, before the appointment of the next Head of CRCC. In the first week of this year, a total of 4,136 instances out of 57,508 ambulatory care were diagnosed with influenza

or similar illness in the capital city alone. 35.6 percent of patients were infants aged 0 to 1, 26.8 percent were aged 2 to 4 and 14.4 percent were aged 5 to 9. Out of 3,098 calls at children's emergency services, 59.5 percent were influenza or similar illness

calls.

Additionally, the Cabinet resolved to grant 3-5 days of paid time off to parents and child guardians, who have a child suffering from influenza, at its regular meeting yesterday. After calling for private entities to sup-

port the implementation of the resolution, the Cabinet informed that the decision will be effective until March 16. Also, Minister of Health and other related officials were ordered to make local medical centers work on Saturdays until March 16. [ZGM]

BANKING SECTOR

TDBM raises MNT credit source from Japanese market

In cooperation with a Japanese investment firm Crowdfunder Inc., the Trade and Development Bank of Mongolia (TDBM) has begun drawing MNT source from the Japanese capital market in a crowdfunding practice.

Crowdfunder Inc. is an advanced investment platform that raises financial source from Japanese investors in crowdfunding to provide credit to small and medium-sized enterprises and support intensifying sectors of developing

countries.

With an aim to business frames of the Mongolia-Japan economic cooperation, and drawing foreign investment and financial sources, the TDBM established its representative office in Tokyo in 2014.

Although Mongolia is considered a high-risk country for Japanese investors, the bank has been constantly promoting the restoring investment climate in Mongolia and is creating credit opportunities for its customers. [ZGM]

INVITATION FOR BID

Date: January 15, 2019

Bid name: **Supply of Enhanced Solid Fuels for Target Groups in Air Quality Management Areas.**
Bid reference number: **NKHAAG-19/005**

The Procurement agency of Capital City would like to invite the eligible bidders to submit their electronic bids for **Supply of Enhanced Solid Fuels for Target Groups in Air Quality Management Areas.**

This bid of goods is being advertised through e-procurement system, thus the detailed information and electronic bidding document may be obtained from www.tender.gov.mn for free.

50,000 (fifty thousand) tugriks should be paid by the interested eligible bidders through e-banking system prior to submission of their bids.

The bid shall be valid for **45** days from the date of the bid opening.

Interested bidders should meet with the following financial and professional experience requirements:

Sales revenue:

Sales revenue should not be less than 50 percent of the total budget in any one of the last 3 years (2015, 2016 and 2017).

The Amount of similar work experience:

Bidder should have experience of supplying similar goods which has value of not less than 50 percent of the total budget in any one of the last 3 years (**2015, 2016 and 2017**).

The Amount of easily convertible assets and the available loan:

It should not be less than 50 percent of the total budget.

The Audited financial statement:

The Last 2 years (2017 and 2018)

The following amount of bid security should be submitted with the bid:

1,803,690 (one million and eight hundred three thousand and six hundred ninety) tugriks;

Bid security must be issued by the authorized commercial banks.

The Bid validity:

Until the end of May 02, 2019.

Bids must be delivered to the address of e-procurement system prior to **10:00 am on February 18, 2019** and will be publicly opened in the presence of interested bidders' designated representatives at **10:30 am on February 18, 2019** in Bid opening room of the Procurement Agency of Capital city.

Foreign bidder is **eligible** to submit a bid.

Margin of domestic preference shall be **applied**.

Interested eligible bidders may obtain electronic bidding document and relevant files from www.tender.gov.mn, www.ub-procurement.mn and further information from the following address:

**The Procurement agency of the Capital City,
10th floor, Capital governing office building No4, Bagatoiruu-15,
4th sub district, Chingeltei district, Ulaanbaatar, Mongolia
Cell: 75757810**

STOCK MARKET

Mongol Basalt: Utilization of IPO financing stands at 56 percent as of December

Tugsbilig.B
@tugsbiligZGM

Mongol Basalt JSC, which raised MNT 6.4 billion from the public through an initial public offering (IPO) last year, has reportedly spent 56 percent of its raised fund for activities promised on the securities presentation.

In other words, MNT 3.6 billion has been spent on multiple activities, such as the expansion of basalt

wool production, basalt spray paint technology, and creating raw material reserves. The company's stock price constantly fell from MNT 380 since the IPO launch, reaching a record low of MNT 243 last December; however, the stock price grew 13.9 percent since the beginning of this year, reaching MNT 279.73 yesterday.

Mongolian Stock Exchange also reported that Mongol Basalt JSC was one of the most actively traded instruments in 2018 as the

secondary market trading alone totaled MNT 3.4 billion, becoming one of the Top 5 actively traded stock.

According to the Chairman of Mongol Basalt JSC Ariunbold Lkhagvajav, the preliminary financial report shows that the company increased its sales revenue by 85 percent in 2018. As of today, five major shareholders own 70 percent of the company's stake and the rest are held by 2,350 small investors. [ZGM]

MINING

Fenwei Energy expects Ovoot coking coal price to reach USD 176-191 per ton

Chinese coal consultant firm Fenwei Energy forecasts the export price of Ovoot coking coal to Haibei Prefecture of the People's Republic of China (PRC) reach USD 176-191 per ton.

The stock price of Ovoot mine operator Aspire Mining Ltd. grew by 5 percent to AUD 0.02 on the last trading day at the Australian Stock Exchange (ASX). Premi-

um coking coals such as Fat and Primary coals, are in particularly high demand within China primarily due to the low ratio of these coals in China's own coal reserves but also due to the growing requirement for higher quality coking coals in the coke industry. Thus, Fenwei Energy expects an annual supply shortage of 16-22 million tons until 2025 and the

demand for Ovoot coking coal to increase during this time.

Aspire Mining previously informed that the preliminary economic assessment of Ovoot mine has been completed and raised the necessary project financing of AUD 15 million. The company's stock price grew by over 80 percent in the last year. [ZGM]

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР



- 07.00 "Өглөө" хөтөлбөр
- 09.00 "Хэцүү анги" УСК 7, 8 дугаар анги
- 10.00 "Нүүдэлчдийн өв соёл: Аргал"
- 15.40 "2019 онд спортын ертөнцөд"
- 19.35 "Судар бичгийн алтан сан"
- 22.15 "Цагаан боол" ОАК 32 дугаар анги



- 07.30 "Бүрэн тайлбар" нэвтрүүлэг
- 11.30 "Алсын хараа" нэвтрүүлэг
- 14.00 "Технологийн шийдэл" нэвтрүүлэг
- 20.30 "Эврика" нэвтрүүлэг
- 21.00 "Мөнгөний урсгал" хөтөлбөр
- 22.00 "Дэвид Рубенштейний шоу" нэвтрүүлэг

БОЛОВСРОЛ

- 08.00 "Дөрвөн өнгө" цаг агаарын хөтөлбөр
- 09.00 "Шидтэнүүдийн клуб" хүүхэдэд кино 15, 16 дугаар анги
- 12.10 "Алтан орд" ОАК 12 дугаар анги
- 19.00 "Надтай гэрлээч" СОАК 5 дугаар анги
- 21.10 "Аяг таа" нэвтрүүлэг
- 23.15 "Баячуудын хорооллын цагдаа" ОАК 4 дүгээр анги
- 07.00 "Өнөө өглөө" хөтөлбөр
- 10.00 "Макс Стил хоёр" хүүхэдэд кино 6 дугаар анги
- 10.30 "Торны цаадах амьдрал" СОАК 11 дүгээр анги
- 13.30 "Ан амьтдын ертөнцөөр" /season-8/ 2 дугаар хэсэг
- 17.30 "Хүчирхэг рэнжерүүд" хүүхэдэд кино 7 дугаар хэсэг
- 21.00 "Төрөх өрөөний тоглоом" 9 дүгээр хэсэг
- 00.30 "Эзэнт гүрэн" ОАК / season-3/ 17 дугаар анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 11
Өвлийн адаг хөхөгчин үхэр сарын хоёр хар мэнгэтэй хөх бар өдөр
Үс засуулбал: Эрхтэн хурц болно
Наран ургах, шингэх: 08.33-17.30
Барилдлага: Үл тохирох
Шүтэн барилдлага: Төрөхүй
Суудал: Мод

Аргын тооллын нэгдүгээр сарын 17, Бархасвадь гараг. Билгийн тооллын 11, Чөлөөт эх одтой, хөх бар өдөр.
Өдрийн наран 08.33 цагт мандан, 17.30 цагт жаргана. Тухайн өдөр морь жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохой жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр хууль цааз гаргах, батлах, хэрэглэх, хулгай дээрмийг номхотгох, гэмтнийг шийтгэх, мал адгуус номхруулах, хараал, жатхыг буцаах, амилуулах, өглөгийн түлгэж хийх, хишиг дуудуулах, хот балгадын үйл, цэрэг, цагдаагийн үйл, гэр, байшингийн суурь тавихад сайн. Золиг гаргах, бомбын үйл, бэрлийн үйлд муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогосод хойш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулбал эрхтэн хурц болно.



"Соёлын довтолгоо" УСК
Хэзээ: 2019.01.19-нөөс
Хаана: Corporate Convention Centre
Тасалбарын үнэ: ₮10 мянга



Сонгодог хөгжмийн концерт
Хэзээ: 2019.01.19-ний 19.00 цагт
Хаана: Улсын филармони
Тасалбарын үнэ: ₮25 мянга



"Уран хас" бүжгэн жүжиг
Хэзээ: 2019.01.19-ний 19.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга

ОНЦЛОХ ҮЗВЭР



"Тамгагүй төр"-тэй өдрүүд

Хаан Арчугт их хатан Цэцэр, бага хатан Гүргэл нар нуган үр төрүүлж өгсөн нь хурмаст тэнгэр, хувь заяаны даажигнал байлаа. Үр заяах нь байтугай үнэрийг нь мартсан эх хатныхаа хүүг өөрийнх нь биш гэдгийг хаан мэдэж буй тул бага хатнаасаа төрсөн хүүгээ өлгийтэйд нь хаанд өргөмжлөхөөр зарлиг буулгалаа. Хааны итгэлт шадар Эгэрэг энэ зарлигийг эсэргүүцэвч яаж ч чадахгүй буцахдаа их хатан

Цэцэрийн хэвлийгээс төрсөн нууц хүүгээ бага хатны хүүтэй арга буюу солив. Хаан Арчуг хүүгээ татаж унадаг өвчтэй, санаа муутай болохыг нь өсөж том болоход нь мэдэн гуниглаж, хаан ширээнд тохирох хүн биш хэмээн яллаж, хорооно. Хайрт хатан Гүргэлээ ч мөн хүүгээ алдсан шаналалдаа цөхөрч суухыг нь харж дийлэхгүй тул мөн өгүүтгэнэ. Харин хааны шадар, санаа муут Эгэрэг энэ бүхнийг зогсоож үл

чадаад хор хорын сэтгэлдээ автахдаа хааны жинхэнэ хүүг хороон, өөрөө төрийн тамга, түмний эрхийг авахаар хаантай тэрсэлдэнэ. Ардын уран зохиолч Б.Лхагвасүрэнгийн "Тамгагүй төр" түүхэн жүжгийг Урлагийн гавьяат зүтгэлтэн Ч.Найдандоржийн найруулснаар энэ сарын 18-20-нд 18.00 цагаас УДЭТ-ын тайзнаа тоглоно. Тасалбарын үнэ 10-25 мянган төгрөг. [ЗГМ]



"Жаргагүй нар" жүжиг
Хэзээ: 2019.01.24-ний 19.00 цагт
Хаана: УДЭТ
Тасалбарын үнэ: ₮10-25 мянга



"Хунт нуур" бүжгэн жүжиг
Хэзээ: 2019.02.02-нд 17.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮10-30 мянга



"Травиата" дуурь
Хэзээ: 2019.02.02-ны 17.00 цагт
Хаана: УДБЭТ
Тасалбарын үнэ: ₮10-20 мянга

ЦАГ АГААР




ФОТО АГШИН



ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ

1		2	3	4	5
		6			
7	8			9	10
		11			
		12		13	
14				15	16
		17			
18				19	

БОСООГООР.

1. Намар ногооноороо байгаа өвс, ургамал шим шүлт
2. Дэлхийн бөмбөрцгийн хамгийн чухал давхарга
3. Монголын спортын оны шилдгүүдэд олгодог шагнал, цом
4. Сүвэгчинд нь утас үлдсэн зүү
5. Омог
8. Сэцэн ханы даншигийн ах дүү 2 их аваргын эцэг, даншигийн заан
10. Ухаалаг, ажилсаг адгуус

12. СГЗ, телевизийн нэрт хөтлөгч
13. Францын алдарт зохиолч Жюль Вернийн төрсөн хот (хэдэн зууны өмнө Британийн гүнт улсын нийслэл байсан)
14. Хойд Солонгосын удам залгасан коммунист удирдагчдын овог
16. Ааш ...
4. Улаанбаатар хотын хамгийн том гамшиг
6. Ямарваа нэг зүйлийг бусдад хүргэж өгдөг хүн
7. Хонжворт тааварт тоглоом
9. Хамгийн сахилгагүй төл мал
11. Газар орон
12. Үндэсний хөгжмийн зэмсэг
14. Эквадор улсын нийслэл, 3000 м өндөрт орших хот
15. Цай, хоолны хэрэгсэл
17. Оросын пролетарийн хувьсгалын удирдагч
18. Шуудангаар илгээх захидалд наадаг зүйл
19. Хөл муутай хүний хэрэгсэл

			О	Р	О	О				
А	Л	Д	А	Р		Н	А	Ц	А	Г
Л		А		Г	Ү	Ю	Г	А		Э
Л	О	М	Б	О		И	Р	В	Э	С
А		А		Д	А	У	Р	А		Э
Х	О	Р	О	О		О	В	Г	О	Р
Ю				Л	О	Г	О			Т
У	Л	С					Б	А	Р	

Өмнөх дугаарын хариу / 01.16

ЗГМ: СУДОКУ

		6	1			8			
	3	2	7	8					
					5				
	8		6						
9	4			1		3			
			3				4		
1									2
		9			2				6
				9	6				1

2	5	1	8	4	6	9	3	7
4	6	8	7	9	3	5	1	2
9	3	7	2	1	5	8	4	6
1	2	3	4	5	9	6	7	8
5	7	6	1	3	8	4	2	9
8	9	4	6	2	7	3	5	1
3	8	2	9	7	4	1	6	5
6	1	5	3	8	2	7	9	4
7	4	9	5	6	1	2	8	3

(Index нөмрөө/Дү хөнийг)



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

ЭРЭЭН-УБ	18.00	11.15
УБ-ХӨХ ХОТ	20.00	20.49
ХӨХ ХОТ-УБ	22.50	11.15
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СҮХБААТАР	21.15	05.12
СҮХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	17.15	19.30
БЭЭЖИН-УБ	20.30	23.00
УБ-ХОНКОНГ	07.50	12.25
ХОНКОНГ-УБ	13.25	18.05
УБ-СӨҮЛ	07.45	12.05
СӨҮЛ-УБ	13.20	16.05
УБ-ТОКИО	08.55	14.30
ТОКИО-УБ	15.30	20.25
УБ-ХӨХ ХОТ	10.30	12.00
ХӨХ ХОТ-УБ	13.00	14.40
УБ-ЭРХҮҮ	06.20	07.20
ЭРХҮҮ-УБ	08.20	09.20

ЭДИЙН ЗАСАГ

Хятадын дөрвөн тэрбумтан \$17 тэрбумыг трастад шилжүүллээ

Татварын аюул нүүрлэмэгч Хятадын тэрбумтнууд хөрөнгөө хамгаалахаар яарч эхлэв.

> 10

Супер нууцлалт квантын кабель

Компаниуд арилжааны алгоритм, данс зэрэг нууцаа хамгаалахын тулд QKD ашиглах сонирхолтой.

> 10

Nike цэнэглэдэг, ухаалаг пүүс худалдаанд гаргана

Nike компани цаашид Adapt технологитой гүйлтийн гутал, спорт бэлтгэлийн хувцас нэмж гаргана.

> 10

Брекситийн улмаас Т.Мэйд итгэл үзүүлэх эсэх асуудал сөхөгдлөө

Олавиа Краусе-Жексон

Британийн Ерөнхий сайд Тереза Мэйгийн боловсруулсан Европын холбооноос гарах төлөвлөгөө буюу Брекситийн асуудлаар санал хураахад уг төлөвлөгөө “үхсэнээс өөрцгүй” боллоо. Одоо түүний Засгийн газарт итгэл үзүүлэх асуудлаар санал хурааж болзошгүй байдал үүслээ. Британийн парламентын төлөөлөгчдийн танхим Ерөнхий сайдын 18 сарын турш ЕХ-той хэлэлцэж зөвшилцсөн баримт бичгийг 432-202 саналаар буцаалаа. Зуу гаруй жилд үзэгдээгүй харьцаатай ялагдал нь сөрөг Лейбор намын зүгээс шинээр сонгууль явуулах санал дэвшүүлэхэд хүргэсэн төдийгүй ЕХ-ны байр суурийг чангатгав.

28 улсыг багтаасан тивийн холбооноос гарах асуудлаар хоёр жилийн өмнө явуулсан бүх нийтийн санал асуулгын дүн Британийн улс төрийг гацааж, ард

иргэд хийгээд улстөрчдийг хэдэн арван жилээр хагаралд оруулав бололтой. Санал хураасны дараа хатагтай Мэй хууль тогтоогчдод хандаж “Төлөөгчдийн танхим гэрээг дэмжихгүй нь тодорхой байна. Гэвч энэ санал хураалт чухам юуг дэмжихгүй байгааг тодруулсангүй” гэжээ. Тэрээр зөвшилцөлд хүрэхийн тулд Умард Ирландын холбоотнууд болон парламентын ахлах улстөрчидтэй хэлэлцээ хийхээ амлаад “Эдгээр уулзалтуудад Засгийн газар бүтээлч сэтгэлээр хандана” гэсэн байна.

Дараа нь Засгийн газрын хэвлэлийн төлөөлөгч тайлбар өгөхдөө Т.Мэй Брекситийн гэрээ унтарсан гэдэгт итгэхгүй байгаа бөгөөд намууд хоорондын хэлэлцээр шинэ гэрээний суурь болно гэж найдаж буй хэмээв. Үүний сацуу Ерөнхий сайд санал хураалтын ач холбогдлыг онцлоод эхний шатанд хууль тогтоогчид

Засгийн газарт итгэж байгаагаа нотлох ёстой гэж мэдэгджээ. Итгэл үзүүлэх эсэх санал хураалтад Т.Мэй ялах анхны шинж тэмдэг ажиглагдсан.

Засгийн газрыг дэмждэг Хойд Ирландын Ардчилсан юнионист нам Т.Мэйг дэмжихээ илэрхийлсэн бол эрх баригч намын Брекситийн талын бүлэг мөн ийм байр суурьтай байгаа. Өнгөрсөн онд энэ бүлэг Брекситийн асуудлаар Ерөнхий сайдыг унагах оролдлого хийсэн боловч амжилтад хүрээгүй агаад одоо саналаа өөрчилжээ. Гэвч юу ч өөрчлөгдөж магадгүй. Т.Мэйн тэргүүлдэг Консерватив нам парламентад олонх бус байгаа нь түүний үйл ажиллагааг хязгаарлахын зэрэгцээ ЕХ-той харилцаагаа хадгалах эсвэл бүрэн таслах



гэсэн эсрэг, тэсрэг саналтай хууль тогтоогчдын ашиг сонирхлын зөрчилд ихээхэн нөлөөлнө.

Их Британи ЕХ-ноос гуравдугаар сарын 29-нд гарах хугацаа заасан учир цагт хавчигдсан Ерөнхий сайд Брюссельд хан-

даж, хугацааг сунгах хүсэлт гаргаж магадгүй. Британийн Сангийн сайд Филип Хаммонд уг асуудлаар бизнесийн удирдагчид болон захирлуудтай уулзалт хийхээр төлөвлөж буй. Санал хураалтын дараа Брюсселээс

ирсэн анхны дохиог ажиглахад эерэг гэж хэлэхээргүй байгаа. ЕХ-ны Ерөнхийлөгч Дональд Туск “Эмх замбараагүй гарах боломж энэ санал хураалтаар нэмэгдлээ. Бид үүнийг хүсэхгүй байгаа ч бэлтгэлтэй байх болно” гэжээ.

Дэлхийн банкинд АНУ-ын нөлөөг хадгалах эрмэлзэл

Эндрю Майеда

Д.Трампын засаг захиргаа Дэлхийн банкны тэргүүнээр АНУ-ын төлөөлөгч байх уламжлалыг үргэлжлүүлэх зорилгоор Дэвид Молпасс, Марк Грин зэрэг хэд хэдэн нэр дэвшигчийг авч үзэж байна. Цагаан ордон урьдчилсан жагсаалт гаргасны дотор гадаадын хөрөнгө оруулалтын газрын дарга, Элчин сайд, PersiCo-гийн захирал асан гэх мэт хүмүүсийн нэр оржээ. Солонгос гаралтай АНУ-ын иргэн Жим Ён Ким хөрөнгө оруулалтын компани руу шилжиж, ДБ-ны ерөнхийлөгчийн албан тушаалыг хугацаанаас нь гурван жилийн өмнө өгөхөө зарласнаар дараагийн хүнийг сонгох шаардлага үүсээд байна.



Сөүл, Вашингтон хоёр Кимийг юугаар урамшуулах вэ

Юкиун Ли

АНУ, Өмнөд Солонгос хоёр Хойд Солонгосын цөмийн зэвсгийг устгах хөтөлбөрийг урамшуулахын тулд зохих алхам хийхээр ярилцаж байна гэж Өмнөд Солонгосын Гадаад хэргийн сайд Кан Киун Ва мэдэгдлээ. Умардын удирдагч Ким Жон Ун АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамптай хоёр дахиа уулзахаар бэлтгэж буй үед холбоотнууд урамшууллын арга хэмжээ боловсруулж, Вашингтон үүнийг хэлэлцээний ширээнд тавьж магадгүй байна. Үүнд бизнесийн харилцааг сэргээхээс гадна хоригийг хэсэгчлэн цуцлах, Солонгосын дайны төгсгөлийг албан ёсоор баталгаажуулах зэрэг алхмууд багтаж болох юм гэж шинжээчид бичжээ.



Renault Карлос Гоныг солиход бэлэн болжээ

Ани Насбаум

Францын авто машин үйлдвэрлэгч Renault Японы шоронд хоригдож буй ерөнхий захирал, зөвлөлийн дарга Карлос Гоны оронд томилгоо хийхээр бэлтгэж байна. КГоныг барьцаагаар суллах оролдлого амжилтгүй болж, хэдэн сараар хоригдох төлөвтэй байгаа гэж эх сурвалж ярьжээ. Ноён Гон Nissan-Mitsubishi хамтарсан бүтцийг удирдаж байхдаа өөртөө хууль бусаар шагнал авсан гэх хэргээр баривчлагдсаны дараа түүнийг шууд огцруулах ёстой байсан гэж зөвлөлийн зарим гишүүн үзэж байсан аж. Шүүхийн ажиллагааны үр дүнгээс үл хамааран тэрээр Францын авто үйлдвэрлэгчийг дахин удирдах боломжгүй болсон гэжээ.



Huawei-г үндэслэгч анх удаа ам нээж, Д.Трампыг магтан сайшаав

Bloomberg News

Huawei Technologies Co.,-ыг үндэслэгч Рэн Жэнфэй олон жил чимээгүй байснаа ам нээж, Хятадын технологийн аваргыг өрнөдийн Засгийн газруудын эсрэг Бээжингийн тагнуулын ажиллагаанд тусалдаг гэсэн АНУ-ын захиргааны шүүмжлэлийг няцаагаад Дональд Трамп татвар бууруулсныг сайшаасан байна. Тэрээр гучин жил оршин тогтносон компанийн хувьд томоохон хямрал үүсээд буй үед ч Бээжингийн албаны хантай байнгын харилцаатай байдаггүй гэжээ. Ноён Рэн Huawei-гийн санхүүгийн захирал, Мэн Ванжоугийн гэх хэрэг явдалд ноён Трамп биеллэн оролцох эсэхийг харзнах байр суурьтай байгаагаа илэрхийлэв.

Хатагтай Мэн түүний том охин бөгөөд Ираны эсрэг Вашингтоны хоригийг зорчсон хэрэгт Канадад баривчлагдаж, одоо АНУ-д шилжүүлэн өгөхийг хүлээн гэрийн хорионд байгаа. 2015 оноос хойш гадаадын хэвлэлд яриа өгөөгүй ноён Рэн ийнхүү ам нээсэн нь Хятадын өсөн нэмэгдэж буй технологийн хүчин чадлын бэлгэдэл болсон Huawei-гийн эсрэг цохилт ямархуу хатуу болсныг харуулж байна.

71 настай тэрээр “Би эх орондоо хайртай, Коммунист намыг дэмждэг. Гэхдээ дэлхий ертөнцөд хохиролтой юм хийхгүй. Миний хувийн үзэл бодол болон Huawei-н бизнесийн хоорондын хувибоог харахгүй байна” хэмээн юм. Рэн



цааш ярихдаа, үйлчлүүлэгчдийн талаар эмзэг мэдээлэл өгөх бэлгэдэл болсон Huawei-гийн эсрэг цохилт ямархуу хатуу болсныг харуулж байна.

панийн төв байрандаа хэлсэн үгэндээ “Huawei бол АНУ, Хятадын худалдааны сөргөлдөөнд өчүүхэн зүйл. Д.Трамп агуу Ерөнхийлөгч. Тэрээр татварыг үлэмж танаж, бизнес туслахаар зориглосон. Гэхдээ АНУ-д хөрөнгө оруулалт татаж, илүү татвар авахын тулд компаниуд болон үлс орнуудтай сайн харилцах хэрэгтэй” гэжээ. Huawei-г үндэслэгч нь бизнесийн хүрээнд домогт хүн бөгөөд ойрын

жилүүдэд дэлхийн чиг хандлагыг тодорхойлох зөрчлийг намжаахад түүний дуу хоолой үнэ цэнтэй.

Тус компанийн зөвлөлийн дарга Кен Хуг оруулаад бүх захирал нь хэвлэлд ярилцлага өгч, тагнуулын ажилд тусалсан гэх мэдээллийг няцаан, нотлох баримт гаргахыг шаардсан. Гэвч өнгөрсөн долоо хоногт тус компанийн Польш дахь борлуулалтын захирлыг тагнуулын хэрэгт баривчилсан хэрэг даруухан амьдардаг ерөнхий захирлыг ам нээхэд хүргэсэн бололтой. Эднийг Польшид баривчлагдсан ажилтнаа нэн даруй халсан. Эдгээр хэрэг явдал бизнест нөлөөлөх таамгийг үл харгалзан ноён Рэн Huawei-ын орлого 2019 онд 25 хувь өсөж, 125 тэрбум ам.долларт хүрэн гэв.

Тэрээр “Huawei нээлттэй компани биш учир бидэнд орлогын сайхан тайлан хэрэггүй. Хэрэв зарим зах зээлд биднийг хүсэхгүй байгаа бол үйл ажиллагаагаа хумина. Бид ажиллаж, ажилчдаа тэжээж байсан цагт ирээдүй бидний талд” хэмээн мэдэгджээ. Ноён Рэнний байгуулсан технологийн аварга компани Alibaba, Tencent хоёрыг хамтатгаснаа илүү борлуулалттай. 2018 онд эднийг ухаалаг утасны борлуулалтаар Apple-ыг гүйцэж, Samsung-ийн ард хоёрт бичигдсэн. Эрхэм Рэнний үгийг өмнөдийн метрополис Шэнжэн дэх компанийн түр байрны хоолны газрын хананд байрлуулж, ажиллагсад нь хүндэтгэн ярилцдаг аж.

Тэрбумтнууд хамтран дэлхийд нөлөөлөх санг дэмжжээ

Аманда Гордон

Оливия Леланд Giving Pledge хандивын байгууллага ажиллуулж байхдаа тэрбумтнуудын талаар хэдэн чухал зүйл олж мэджээ. Тэд бие биесээс сурах дуртай. Тэд мөн дэлхийн ядуу хүмүүсийг өөд татах сонирхолтой боловч зөв боломжийг эрж олоход хүнд байдаг аж. Тиймээс Леланд Co-Im-ract нэртэй зөвхөн хандивлагчдад зориулсан сан үүсгэн байгуулжээ. Энд хандивлагчдын мөнгийг хуримтлуулж, Африк, Ази, Латин Америкт хэрэгжсэн баталгаатай төслүүдийг дэмжих шийдвэр гаргахад тэднийг оролцуулдаг байна.

Нэг жилийн настай сан эхний 80 сая ам.доллараа цуглуулж, 25 дэмжигчтэй болсны дотор Мелинда Гейтс, Жефф Скотт, Рохини ба Нандан Нилекани нар бий. Бил Акманы сан эднийд мөнгө хандивладаг бол Сколлын сангаас ч мөнгө орж ирдэг. Ирэх таван жил таван төсөлд санхүүгийн болон техникийн тусламж үзүүлэхээр төлөвлөсөн нь есөн сая хүнд хүрэх бөгөөд хатагтай Леланд Рокефеллерийн сангийн захирлаар ажиллахын сацуу төслүүдийг хэрэгжүүлэхэд тусална. Тэрээр “Бидний хийж буй гол ажил бол буяны үйл ажиллагаа тусална. Тэрээр “Бидний хийж буй дахад уу гэсэн асуултад хариулах явдал” хэмээн онцлов.

Last Mile Health төсөл Либерийн



Эрүүл мэндийн яамтай хамтран хөдөөгийн 1.2 сая хүнд эмнэлгийн анхан шатны үйлчилгээ хүргэх зорилготой. Түүнчлэн Латин Америк болон Энэтхэгт мөнгөний дэмжлэг үзүүлэх, Бангладешт сургалт зохиох зэргээр дэлхийн 43 улсад үйл ажиллагаа явуулж байна. Рокефеллер, Гейтс, Сколлын сангууд арав гаруй жилийн хугацаанд тус бүр 25-50 сая ам.долларын хандив өгсний нэлээд хэсэг нь аялал, уулзалтад зарцуулагддаг. Гэвч хэт ядуу хүн амд туслахад тэрбумтан хандивлагчдыг оролцуулах нь харьцангуй шинэлэг алхам юм.

Нөгөө талаас хөрөнгө, баялаг цөөн гарт хуримтлагдаж, олон улсын асуудалд маш бага хувь нь зарцуулагдаж байгаа нь ийм төслүүдэд анхаарах сэдэл болсон байж магадгүй. Рокефеллерийн сангийн ерөнхийлөгч Ражив Шах “Дэлхий даяар хамгийн үгээгүй гэр бүл, хүүхдийн амьдралд хөрөнгө оруулах нь бидний хийж чадах хөрөнгө оруулалтын дээд өгөөж гэдгийг бид мэднэ. Бид хандивлагчийн хувьд мөр зэрэгтэн хамгийн өндөр хана хэрмийг давахуйц төслүүдийг зохиож байгаа” гэсэн юм.



Эдийн засаг

татвар төлөхөө хойшлуулах замаар хугацаа хожиж буй төдий” хэмээн Хонконгод активын менежментийн үйлчилгээ эрхэлдэг Noah International Holdings-ын гүйцэтгэх захирал Оскар Лю дүгнэж байна.

БНХАУ-ын татварын шинэ хуульд оффшор траст сангууд татвар төлөх ёстой талаар тодорхой заалт байхгүйг ноён Лю анхааруулж байна. Мөн траст сангаар итгэмжлэл хүлээж буй тал буюу бенефициар БНХАУ-ын татвар төлөгч эсэх гэх мэт бусад хүчин зүйлсээс хамаарна хэмээн захирал тайлбарласан юм.

Хүн амын баян чинээлэг хэсэгт оноох татвар нь Хятад орны татварын тогтолцоог өргөн цар хүрээтэй шинэчлэх арга хэмжээний бүрдэл болж байна. Тус улс удааширч буй эдийн засгаа өөд татахын тулд эн тэргүүнд татвар бууруулах арга хэмжээг түлхүү авна. JPMorgan Chase-ийн эдийн засагчдын тооцоогоор татварын өөрчлөлт БНХАУ-д хоёр их наяд юань (300 тэрбум ам.доллар) буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.2 хувьтай тэнцэх гарлагатай тусна. Гүүр, төмөр замын ажлын санхүүжилттэй уялдан үүссэн Хятад орны өр, зээлийн аварга

Хятадын дөрвөн тэрбумтан \$17 тэрбумыг трастад шилжүүлээ

Винас Фэн, Блэйк Шмидт

Хятадын дөрвөн ч магнат шинэ он гарахын өмнөхөн хөрөнгөөсөө 17 тэрбум ам.долларыг гэр бүлийн траст санд шилжүүлсэн нь тус улсын баячууд чангарсаар байгаа татварын тогтолцооноос эд баялгаа хамгаалахаар хичээж буйн илрэл боллоо. Үл хөдлөх хөрөнгө хөгжүүлэгч Sunac China Holdings-ын тэргүүн, тэрбумтан Сунь Хунбин компанид эзэмшдэг хувь хөрөнгийнхөө ихэнхийг South Dakota Trust-д 12 дугаар сарын 31-нд шилжүүлснийг Хонконгод нэгдүгээр сарын 12-нд ил болсон баримт нотолж байна.

Хятадын тэргүүн баян эмэгтэйн нэг, Longfor Group Holdings-ын тэргүүн У Я-жунь ч сүүлийн хэдэн долоо хоногт мөн адил ийм ажил амжуулжээ. Хүнсний бүтээгдэхүүний Dali Foods Group, Zhou Hei Ya International Holdings-ын эзэн баян магнатууд ч мөн трастад хөрөнгөө шилжүүлсэн байна.

Нэр дурдсан компаниуд бүгд Хонконгийн хөрөнгийн биржид бүртгэлтэй. Хувиа траст санд шилжүүлсэн нь хөрөнгө өвлүүлэх үүднээс авсан арга хэмжээ хэмээн Sunac мэдэгдсэн. Эдгээр магнатын хөрөнгө эзэмш-

лийн бүтэц нь Британийн Виржинийн арлуудад бүртгэлтэй байгууллага, компаниудтай холбогддог. Тайлбар хүсэхэд Хятадын компаниудын төлөөлөгч хариу өгсөнгүй.

Энэ онд масс иргэдийн татварыг хөнгөлж, баячуудыг татвараар шахах засгийн газрын бодлого Хятадын супер тэрбумтнуудыг түгшээж эхэлсэн цаг үед траст санд их хэмжээний хөрөнгө шилжив. Хятад оронд хувийн эд баялаг 2018 онд 24 их наяд ам.доллар болж өссөнтэй уялдан татвар хураагчдын ажил түвэгтэй болж, баян чинээлэг

ХЯТАДЫН МӨНГӨНИЙ ИХ НҮҮДЭЛ

Нэр	Компани	Огноо	Шилжүүлсэн хувьцаа ам.доллар	Өөрчлөлт
Сунь Хунбин	Sunac China Holdings	2018.12.31	4.5 Тэрбум	Сунь овогтын хувьцааны ихэнх нь HBS гэр бүлийн траст санд шилжсэн
Тан Жяньфан	Zhou Hei Ya International Holdings	2018.12.18	0.6 тэрбум	Тан овогтын оффшор компаниудыг гэр бүлийн траст сан эзэмшдэг
У Я-жунь	Longfor Group	2018.11.21	7.9 тэрбум	У овогтын трастын мэдэлд байсан хувьцаа охиных нь байгуулсан траст санд шилжсэн
Шью Шихуй	Dali Foods Group	2018.12.07	4.2 тэрбум	Эхнэр, охиных нь мэдэлд байсан хувьцаа Шью овогтын байгуулсан шинэ траст санд шилжсэн

айл өрх траст сан зэрэг халхавч ашиглан хөрөнгөө бултуулахаар оролдох нь ихэслээ.

“Оффшор траст сангууд татвараас 100 хувь булгаж чадахгүй л болов уу. Тэрбумтнуудын хувьд

дарамт ч татварын шинэчлэл өрнүүлэхэд хүрсэн нэг шалтгаан.

Шинэ он гарахын өмнө Сунь овогтын шилжүүлсэн хөрөнгө 4.5 тэрбум ам.доллар. Зөвхөн 2017 онд хөрөнгө нь гурав дахин өссөн Сунь Хунбин бизнесийн замналынхаа сүүлийн хэсэгт шоронд сууж, Хятадаа аварга нь болно хэмээн тооцоолж байсан хөрөнгөө зарахаас аргагүйд хүрсэн юм. Тэрбээр 2017 оны тавдугаар сард Sunac-ын гүйцэтгэх захирлаар өөрийн хүү Кевин Жэ-И Сунийг томилсон. Хүү нь захирал болох үедээ 27 настай байжээ.



Супер нууцлалт квантын кабель

Жереми Кан

Доод Манхэттэн, Нью Жерсийг холбосон Холландын нүүхэн хонгил дотуур оргил цагаар зорчигсод машинных нь цонхоор харагдах гадна талд дэлхийн харилцаа холбооны ирээдүйг туршиж байгааг хэрхэн мэдэх вэ.

Хонгилын ханаар татсан мяндсан оптик кабель буюу шилэн кабельд банкны нууц өгөгдлийг болзошгүй тагнуулаудаас хамгаалах квантын механикийн хүч оршиж байгаа.

Уг кабелиар өгөгдөл дамжуулахдаа QKD (Quantum Key Distribution) буюу квантын түлхүүр хуваарилалттай технологи ашиглаж байгаа юм. Орчин үед гайгүйхэн шиг тагнуулын байгууллага энгийн мяндсан оптик кабельтэй сүлжээнд хөндлөнгөөс нэвтэрч, мэдээлэл нь хандаж чадна. Шилэн кабелийг жижиг хавчаараар хавчиж, тусгай зориулалттай техник төхөөрөмж холбоод л дижитал тэг, нэг дамжиж буй гэрлийн туяаг “олзолж” орхино. Анзаарагдахуйц ямар ч удааширал байдаггүй учраас мессеж, мэдээллийг нь зам зуураас хэн нэг этгээд “уншаад

байгаа”-г хэрэглэгчид мэдэх ч үгүй.

Бэрхшээлийг шийдвэрлэхийн тулд гэрлийг долгион төдийгүй эгэл хэсэг хэмээн авч үздэг квантын физикийг QKD технологид ашигласан юм. QKD систем бүхий мяндсан оптик шугамын хоёр төгсгөлд өгөгдлийн ямар ч төвд байж л байдаг, гаднаасаа энгийн хар хайрцаг аятай харагдах сервер байрлана. Серверүүд өгөгдөл дамжуулахдаа ширхэг нь ганц фотоноос томгүй гэрлийн сулхан лугшаагаар “буудна”. Гэрлийн лугшааны замд саад тохиолдох юм бол нөгөө үзүүрт очихоор тооцоолсон нано секундэдээ амжиж хүрэхгүй учраас илгээгч, хүлээн авагч хоёр холбоог нь зам зуураас ашиглаж байгаа даруй мэдэх болно.

“Санхүүгийн компаниуд QKD технологийг хувьсгал гэж ойлгож байгаа”-г өнгөрсөн намраас хойш Холландын хонгилд уг кабелийг хариуцан ажиллаж буй Quantum Xchange компанийн гүйцэтгэх захирал Жон Приско тайлбарлав. Кабелийн нь хэд хэдэн том банк, активын менежментийн компани туршин ашиглаж байгааг захирал

өгүүлсэн ч хэлэлцээрийн дагуу хүлээсэн үүрэгтээ захирагдан нэрийг нь дурдахаас татгалзлаа. Компаниуд арилжааны алгоритм, үйлчлүүлэгчдийн данс зэрэг эмзэг нууцаа хамгаалахын тулд QKD ашиглах сонирхолтой байгааг захирал нэмж дурдсан юм. Мэрилэнд муж улсын Бетесдад төвтэй Quantum Xchange нь шилэн кабелиа зүүн эргийн Бостоноос баруун эргийн Вашингтон, Колумбын тойрог хүртэл татаж, АНУ-ын Засгийн газрын агентлагуудын хэрэглээ болгох найдлага тавьж байна.

Квантын түлхүүрээр нууцалсан холбооны зах зээл ойрын жилүүдэд 50 саяас 500 сая ам.долларт эргэлдэнэ гэсэн тооцоо бий. Харин судалгааны Global Industry Analysts компани QKD болон холбогдох бусад технологийн зах зээл 2024 он гэхэд хоёр тэрбум ам.долларт хүрнэ хэмээн тооцоолов. БНХАУ-ын Засгийн газар Бээжин Шанхайн хооронд 1995 километр урт QKD хамгаалалттай шугам тавьсан төдийгүй сансраас уг технологийг ашиглан мэдээлэл дамжуулж, хүлээн авах туршилт хийсэн юм. АНУ-д зургаан QKD старт-

ап компани үйлчлүүлэгчтэй болсон. Цахилгаан станцуудын харилцаа холбооны нууцлалыг сайжруулах туршилтын төсөл хэрэгжүүлэхээр Өмнөд Калифорнийн Qubitekk старт-ап компани АНУ-ын Эрчим хүчний яамтай гэрээ байгууллаа. Их Британийн BT Group, Японы NTT корпорац зэрэг харилцаа холбооны аваргууд ч сүлжээний дэд бүтцээ уг технологиор хамгаалах төлөвлөгөөтэй.

Орчин үеийн цахим сүлжээ тэртээ тэргүй нууцлалтай юм чинь дахиж ажил удах хэрэг байна уу гэсэн асуулт бий.

Мэдээллийг шифрлэж, шифрлэсэн мэдээллийг эргүүлэн тайлахад ашигладаг дижитал түлхүүрийг халдлага үйлдэгч этгээд гартаа оруулах тохиолдолд шифрлэх технологи үр дүнгүй. Дижитал түлхүүрийг хожим нэмж, шифрийн нууцлалыг нь сайжруулсан. Гэсэн хэдий ч Үндэсний аюулгүй байдлын агентлагын хуучин гэрээлэгч Эдвард Сноуден 2013 онд ил болгосон баримтаас үзвэл, дэлхийн интернэт траффикийн ихэнхийг хянагч АНУ-ын Засгийн газар ийм бат цоожийг хүртэл эвдэж чадаж байгаа юм.

Nike цэнэглэдэг, ухаалаг пүүз худалдаанд гаргана

Эбен Нови-Уильямс

Nike компани хэрэглэгчдийн талаар ахиухан мэдээллийг гутлаар нь дамжуулж авах шинэ арга бодож олжээ. Мягмар гарагт болсон Future of Footwear арга хэмжээний үеэр тус компани Nike Adapt хэмээх пүүзний шинэ концепт сонирхуулсан юм. Эзэмшигчийнхээ хэрэглээг real-time горимд бүртгэдэг уг загвар Nike компаниас хэрэглэгчдэдээ зөвлөгөө өгөх, бүтээгдэхүүнээ ахиу борлуулахад нь тусална.

“Шинэ өдөр эхэллээ. Та бид footwear-ээс firmware (өргөн хэрэглээний цахим төхөөрөмжийн суурь программ)-д шилжиж байгаатай адил зүйл болж байна” хэмээн Nike-ын гутлын инновац эрхэлсэн захирал Майкл Донахью мэдэгдэв.

Мэдээлэл бүртгэх чадвартай Nike Adapt хэрэглэгчдийн өгөгдлийн халдашгүй байдалтай холбоо бүхий сонголттой. Өгөгдлөө бусадтай хуваалцахгүй гэж сонговол уг гутлын олон шинэ чадварыг ашиглахгүйгээр хэрэглэх юм. Үйлдвэрлэгч нь энэхүү сагсан бөмбөгийн гутлыг 350 ам.доллараар борлуулах төлөвлөгөөтэй.

Nike Adapt үдээсгүй, хэрэглэгчийн үзэмжид ний-

цүүлж автоматаар хөлд чангарна. Чанга, сулыг нь гар утасны аппликэйшнээр тохируулж болно. Сенсор, акселерометр, гироскоп бүхий энэхүү гутал нь эзэмшигчийнхээ бүхий л хөдөлгөөн, үйлдлийг бүртгэж явах юм. Гутлыг хоёр долоо хоног тутамд цэнэглэнэ.

“Хоёр хөлдөө хоёр ухаалаг утас угласнаас ялгаагүй” хэмээн Nike-ийн дижитал бүтээгдэхүүн хариуцсан захирал Майкл Мартин тайлбарлаж байлаа.

Тус компанийн хувцас хэрэгслийн борлуулалт эрчимтэй нэмэгдсээр байгаа ч өмнөх санхүүгийн жилд олсон 36.4 тэрбум ам.долларын орлогын 61 хувийг нь гутлаас олжээ.

Nike нь түүхэндээ хамгийн үнэтэй буюу 720 ам.долларын сникерийг 2017 онд цөөн тоогоор худалдаанд гаргаснаасаа хойш өөрөө үдэгддэг гутал үйлдвэрлэх болсон юм. Boston Celtics-ийн Жэйсон Татум энэ долоо хоногийн сүүлээр NBA-ийн тоглолтод өмсөн гарч ирэх шинэ загварыг суваг, жижиглэн худалдаачдаар дамжуулан борлуулахад төлөвлөж байна. Орегон муж улсын Бивертонд байрладаг Nike компани цаашид Adapt технологи бүхий гутлтийн гутал, спорт бэлтгэлийн хувцас, өргөн хэрэглээний бүтээгдэхүүн нэмж гаргахаар төлөвлөж байна.



Эдийн засаг

МАКРО ЭДИЙН ЗАСАГ

“Эдийн засаг эргэн хүндрэх магадлал тун ойрхон”

2019 онд
инфляцыг
анхааралтай
ажиглах хэрэгтэй

Г.Илч
ЗГМ

Дэлхийн банкны эдийн засагч Б.Даваадалайтай Монгол Улсын макро эдийн засаг, мөнгөний бодлого зэрэг сэдвээр ярилцлаа.

-Улиран одсон 2018 он Монголын эдийн засагт ямар жил болж өнгөрсөн бэ?

-Эдийн засаг 2018 онд багагүй сэргэж, төсөв, мөнгөний бодлогод эерэг үр дүн ажиглагдлаа. 2016 оны эцэс, 2017 оны эхэн үетэй харьцуулахад эдийн засагт цөөнгүй эерэг үзүүлэлт харагдсан. Нэгдүгээрт, энэ нь манай улсын гадаад эрэлттэй холбоотой. Ялангуяа, манай голлох түүхий эд болох нүүрсний экспорт сэргэж, үнэ нь өслөө. Хойд Солонгосын нүүрсний нийлүүлэлтэд БНХАУ хязгаарлалт тавьсан нь манай улсын нүүрсний экспортын гадаад эрэлтийг огцом өсгөсөн. Мөн 2017 оны тавдугаар сараас Засгийн газар болон төв банк олон улсын хөгжлийн түншүүдтэй хамтран хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн. Зарим ажлыг эс тооцвол хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд төсөв, мөнгөний бодлогод томоохон шинэчлэлүүд хийлээ. Харин төсөв, нийгмийн халамжийн бодлогод хийх байсан хоёр чухал тохиргоог хараахан хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал, Хүн амын орлогын албан татварыг шалтгалтай болгох, тэтгэврийн насыг нэмэх санаачилга хэрэгжсэнгүй. Эдгээрийг эс тооцвол бусад голлох арга хэмжээ амжилттай хэрэгжсэн гэж хэлж болно.

Монголбанк Төв банкны тухай хуулийг шинэчилж, төсвийн шинжтэй арга хэмжээн дэх оролцоогоо хумьсан нь онцолж болох ахиц. Мөн банкны салбарт олон чухал хууль, журам баталлаа. Хамгийн гол нь банкны салбарт активын чанарын үнэлгээ хийж, үр дүн нь харьцангуй нааштай гарсан. Гэхдээ уг үнэлгээний үр дүнг цаашид баталгаажуулах, банкны системийн хөрөнгийн дутагдлыг нөхөх асуудал чухал хэвээр байна.

-2018 оны эхэнд Дэлхийн банк Монголын эдийн засгийн өсөлтийн таамаг гаргасан. Тухайн үеийн төсөөлөл өнөөгийн бодит гүйцэтгэл хоёр хэр зөрүүтэй байна вэ?



Эдийн засаг сэргэж байгаа нь үнэн. Гэхдээ суурь сорилтууд хэвээрээ байна.

Б.Хасуй / ЗГМӨ

-Эдийн засгийн өсөлт төсөөлснөөс харьцангуй сайн байлаа. Сүүлийн гурван улирал дараалан ДНБ зургаагаас дээш хувиар өссөн. Хэдийгээр өнгөрсөн оны эцсийн үзүүлэлт ил болоогүй ч Дэлхийн банк 2018 оны эцэст Монгол Улсын эдийн засаг 5.9 хувиар өсөх болов уу гэж таамаглаж байна. Өнгөрсөн оны эхний гурван улирлын байдлаар ДНБ-ий өсөлт 6.4 хувьд хүрсэн. Гэхдээ оны сүүлчийн улирлын гүйцэтгэлд Дэлхийн банк бага

Банкны зээл, импортыг хязгаарлах нь чухал

зэрэг болгоомжтой хандаж байна. Өнгөрсөн арвандүгээр сарын дунд үеэс эхлэн нүүрсний тээвэрт гацаа үүссэн болон улирлын шинж чанартай шалтгааны улмаас эдийн засгийн өсөлт өнгөрсөн улиралд бага зэрэг саарч, 5.9 хувь орчимд хүрэх болов уу. Гэхдээ энэ нь тун болгоомжтой хандсан төсөөлөл гэдгийг хэлэх хэрэгтэй. Мөн энэ төсөөлөл нь 2017 оны сүүлч, 2018 оны эхэнд таамаглаж байсантай харьцуулахад өндөр дүн. Төсвийн орлого бараг 24 хувиар давж биелснээс гадна тодотгол

хийгээгүй учраас зардлаа санхүүжүүлэх хангалттай боломж, орон зай байна.

Төсөв, мөнгөний бодлогод эерэг үр дүн гарсан нь зарим сөрөг нөлөө дагуулсан. Тухайлбал, эдийн засгийн идэвхжил импортыг өсгөлөө. Дотоодод үйлдвэрлэл өндөр хөгжөөгүй учраас эдийн засаг сайжрахын хэрээр импорт өсөж байна. Импортын жилийн өсөлт нь сүүлийн 12 сарын дунджаар бараг 40 хувьтай гарсан. Түүнчлэн санхүүгийн салбарт хэрэглээний зээл өслөө.

Ийнхүү зээл болон импортын өндөр өсөлт гадаад секторын дарамтыг нэмж, улмаар валютын нөөц болон ханшид сөргөөр нөлөөлсөн. Гэхдээ төв банк энэ оны хоёрдугаар хагаст хэрэглээний зээлийг хумих, аж ахуйн нэгжүүдийг чиглэсэн санхүүжилтийг дэмжих бодлогыг шат дараатай хэрэгжүүлж буйг дурьдах нь зөв болов уу.

-Төв банк хэрэглээний зээлийн өр, орлогын харьцааг 70 хувиар тогтоож, хугацааг 30 сар болгосон. Энэ бодлогын үр дүнг та хэрхэн харж байгаа вэ?

-Дэлхийн банк төв банкны эдгээр алхмыг бодлогын түвшинд дэмжиж байгаа. Гэхдээ хэрэгжих хугацаа нь хоцров уу гэж бодож байна. Мэдээж, шинэ бодлогод иргэд, аж ахуй нэгжүүд дасан зохицоход хугацаа хэрэгтэй. Гэхдээ гадаад зах зээл, төлбөрийн тэнцэл, валютын ханшид ирж буй

дарамтыг авч үзвэл хэрэгжих хугацааг нь ойртуулсан бол илүү үр дүн гарах байсан болов уу.

Төв банк оны өмнөхөн бодлогын хүүг нэмснийг дэмжиж байна. Гэхдээ хугацааны хувьд бага зэрэг хоцорч бодлогын хүүг өсгөсөн байх талтай.

-Тэгвэл 2019 оныг та хэрхэн төсөөлж байна вэ. Гадаад орчинд тодорхой бус байдал нэмэгдэж буй энэ үед төв банкны бодлого аль чиглэлд хэрэгжих нь эрсдэлийг бууруулах бол?

-Төв банкны хувьд үнийн тогтвортой байдал хамгийн чухал. Инфляцыг зорилтот түвшинд хадгалах нь Монголбанкны тэргүүн зорилт болж таарч байна. Сүүлийн хэдэн жилийн хугацаанд төв банк инфляцыг найман хувьд хадгалахаар зорьж байгаа. 2018 онд инфляц харьцангуй зорилтот түвшинд байлаа. Харин 2019 онд инфляцыг анхааралтай ажиглах хэрэгтэй. Инфляцад эрсдэл үүсэж байна.

● **2019 онд маш хянамгай хандаж, асуудлаа зөв шийдэж, бэлтгэлээ базааж авахгүй бол 2017 оных шиг дефолт зарлах түвшинд очиж болзошгүй.**

● **Валютын ханшид ирэх дарамтыг бууруулахын зэрэгцээ валютын нөөцөө зохистой түвшинд хадгалах нь төв банкны анхаарах ёстой гол ажил.**

● **Уул уурхайн салбарын томоохон төслүүдийн хэрэгжилтийг шуурхайлах хэрэгтэй.**

эсвэл маш богино хугацаанд бусад бараа, бүтээгдэхүүний үнийг өсгөдөг. Тиймээс 2019 онд төв банкны анхаарах гол зүйл инфляц гэж бид үзэж байна. Мэдээж, мэргэжлийн байгууллага үүнд анхаарч байгаа байх. Хоёрдугаарт, банкны зээл, импортыг хязгаарлах нь чухал байна. Макро зохистой бодлогын арга хэрэгслүүд, мөн бодлогын хүүг өсгөхөөс гадна өөр ямар шийдлүүд байж болох вэ. Энэ асуудалд онцгой анхаарч, валютын ханшид ирэх дарамтыг бууруулахын зэрэгцээ валютын нөөцөө зохистой түвшинд хадгалах нь төв банкны анхаарах ёстой гол ажил.

Гадаад эдийн засгийн орчны тодорхой бус байдал өсөж байна. Үүнээс үүдэн түүхий эдийн үнэ ирэх онуудад буурах хүлээлттэй байна. Ийм үед төв банк аль болох алгуур, болгоомжтой, үнийн тогтвортой байдлыг хадгалсан, төсвийн бодлоготойгоо маш сайн уялдаатай бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй.

-2019 онд төсвийн бодлого тэлэхээр байгаа. Энэ нөхцөлд мөнгөний бодлогын орон зай хумигдах уу?

-2017, 2018 онд эдийн засагт тохиргоо хийх хөтөлбөрийн нөлөөгөөр төсвийн зардал харьцангуй дүнгээрээ нэмэгдээгүй. Харин 2019 онд зардал мэдэгдэхүйц өсөхөөр болсон. Ялангуяа, хөрөнгө оруулалт их хэмжээгээр нэмэгдэж буй. Эмпирик судалгаа болон түүхэн тоон мэдээлүүдийг үндэслэж харахад төсвийн хөрөнгө оруулалт нэмэгдсэнээр импорт их хэмжээгээр өсдөг. Ингэснээр валютын ханшид ирэх дарамт нэмэгдэнэ. Энэ тохиолдолд мөнгөний бодлогын орон зайг аль болох хадгалж, бодлогоо хэрэгжүүлэх нь чухал. Нэг талаас төсвийн зардлаар дамжиж, эдийн засагт тэлэлт явагдах нь. Гэтэл мөнгөний бодлогоор төсвийн тэлэлтийг аль болох зөөлрүүлэх, шаардлагатай тохиолдолд мөнгөний бодлогыг хатууруулах чиглэлд ажиллах нь зүйтэй болов уу. Дээрээс нь улс төрийн эрсдэл бий. 2020 онд сонгууль болно. 2019 он бол сонгуулийн өмнөх жил. Сүүлийн үед ЖДҮХС-гийн зарцуулалтаас үүдэн эрсдэлүүд нэмэгдэж байгаа. Үүнийг олон улсын байгууллагууд, гадаадын хөрөнгө оруулагчид анхааралтай ажиглаж байна.

Үүнээс гадна уул уурхайн салбарын томоохон төслүүдийн хэрэгжилтийг шуурхайлах хэрэгтэй. Төлөвлөсөн хугацаандаа, зөв зохистойгоор хэрэгжих үү, үгүй юу гэдэг нь анхаарал татаж байна. “Тавантолгой”, “Оюутолгой” зэрэг томоохон төслүүдэд хэр ахиц гарах нь бусад төслийн үйл ажиллагаа, эдийн засгийн ирээдүйн төлөвт чухал нөлөөтэй.

2019-2020 он бол Монголын эдийн засагт маш чухал жил. Яагаад гэвэл, 2021 оноос бид том хэмжээний зээлийн эргэн төлөлтүүдийг хийнэ. Тэгэхээр 2019 онд маш хянамгай хандаж, асуудлаа зөв шийдэж, бэлтгэлээ базааж авахгүй бол 2017 оных шиг дефолт зарлах түвшинд очиж болзошгүй.

Эдийн засаг сэргэж байгаа нь үнэн. Гэхдээ суурь сорилтууд хэвээрээ байна. Экспортын орлого тодорхой хэдэн бүтээгдэхүүнээс хамааралтай. Эдийн засаг төрөлжөөгүй, орлого олох орон зай бага. Хил дээр багахан асуудал үүсэхэд л бүх зүйл шат дараатайгаар нурах аюултай байна. Тэгэхээр эдийн засгийн дархлаагаа сайжруулж, удахгүй төлөх том төлбөрүүдэд бэлтгэлтэй байх нь хамгийн чухал. Засгийн газар ч, төв банкны түвшинд ч тэр уялдаатай байж, зохистой бодлого хэрэгжүүлэхгүй бол эдийн засаг эргээд ихээхэн хүндрэлд орох эрсдэл маш ойрхон гэдгийг санах хэрэгтэй.

ЗГМ ТОВЧХОН

» мөнгөний нийлүүлэлт

19.5

Их наяд төгрөг. Өнгөрсөн оны эцсийн байдлаар мөнгөний нийлүүлэлт дөрвөн их наяд төгрөгөөр өсөж, 19.5 их наяд төгрөгт хүрлээ.

» ХАДГАЛАМЖ

0.5

Их наяд төгрөг. Банкны салбар дахь валютын хадгаламж 0.5 их наяд төгрөгөөр өсөж, гурван их наяд төгрөгт хүрлээ. Харин төгрөгийн хадгаламж 1.6 их наяд төгрөгөөр нэмэгдсэн байна.

» ТҮҮХИЙ ЭД

0.1

Хувь. Олон улсын зах зээлд Brent төрлийн газрын тосны ханш 0.1 хувиар буурч, баррель нь 60.57 ам.доллар хүрсэн байна. Харин WTI төрлийн газрын тосны ханш 0.2 хувиар суларч, 51.99 ам.доллартай тэнцэв.

» ОРОН СУУЦ

0.9

Хувь. БНХАУ-ын 70 хотод өнгөрсөн дугаар сард шинэ орон сууцны үнийн өсөлт 0.9 хувиар саарчээ. Эдгээр хотод үнийн өсөлт 0.77 хувьд хүрчээ.

» ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

1.5

Их наяд юань. БНХАУ 2020 он гэхэд спортын салбарт оруулах хөрөнгө оруулалтын хэмжээг 1.5 их наяд юаньд хүргэнэ гэж тус улсын Спортын ерөнхий газрын Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооноос мэдээллээ.

» УУЛ УУРХАЙ

176

Ам.доллар. Овоотын коксжих нүүрсний ханш урт хугацаанд тонн нь 176-191 ам.долларт хүрч, Хэбэй мужийн хэрэглэгчдэд хүрэх боломжтой гэж Fenwei Energy компани таамаглав.

» ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

20

Төгрөг. “Түмэн шувуут” компанийн үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны захиалга эхэллээ. Тус компани 20 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 200 сая ширхэг энгийн хувьцаа санал болгож байгаа юм.

» ХҮН АМ

Хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын туршилтын тооллого өчигдөр дууслаа.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,666.72
Евро	3,078.06
Японы иен	24.71
ОХУ-ын рубль	39.86
БНХАУ-ын юань	392.67
БНСУ-ын вон	2.38

УУЛ УУРХАЙ

China Coal Energy-гийн нүүрсний олборлолт 2.1 хувиар өсөв

М.Золбоо
Шинжээч

China Coal Energy компанийн нүүрсний олборлолт өнгөрсөн онд жилийн дүнгээр 2.1 хувиар өсөж, 77 сая тонн хүрсэн байна. Ялангуяа, арванхоёрдугаар

сарын борлуулалт 28 хувиар өссөн нь нийт олборлолтын 10 гаруй хувийг бүрдүүлжээ.

Тус компанийн борлуулалт 2018 онд өмнөх оныхоос 20 орчим хувиар өсөж, 155.7 сая тонн хүрсэн. China Coal Energy компанийн үйл ажиллагаа, олборлолтод БНХАУ-ын Зас-

гийн газрын макро эдийн засгийн бодлого, зах зээлийн нөхцөл байдал, цаг агаар зэрэг хүчин зүйлс нөлөөлжээ. China Coal Energy нь China Shenhua Energy-ийн дараа бичигддэг БНХАУ-ын уул уурхайн хоёр дахь том компани юм.

ӨР ТӨЛБӨР

Дэлхийн өр түүхэн дээд түвшинд ойртлоо

Дэлхийн улс орнуудын өрийн хэмжээ 244 их наяд ам.доллар буюу түүхэн дээд түвшиндээ ойртсоныг Олон улсын санхүүгийн институт мэдээллээ. Энэ нь дэлхийн эдийн засгаас гурав дахин өндөр дүн аж.

Улс орнуудын өрийн ДНБ-тэй

харьцуулсан хэмжээ өнгөрсөн оны гуравдугаар улиралд 318 хувь давжээ. Энэ дүн 2016 оны гуравдугаар улиралд 320 хувь буюу түүхэн дээд түвшинд хүрч байжээ. Ялангуяа, БНХАУ, Энэтхэг зэрэг хөгжиж буй орнууд өрийн өсөлтөөр тэргүүлж буй.

Эдгээр орны өрийн хэмжээ 2016 оноос хойш 20 гаруй хувиар нэмэгджээ. Олон улсад төв банкууд бодлогын хүүгээ нэмж буй энэ үед Засгийн газруудыг өрийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахыг ОУВС анхааруулж байна.

Эдийн засаг

Шинэ бизнесүүдийн зардлыг цахим худалдаа хэмнэдэг

Дундын зуучлагч байхгүй тул түрээс, нэмэлт зардал төлөх шаардлагагүй

Б.Баяртогтох
@bayartogtokhZGM

Өмнөд хөршид өрнөж буй цахим худалдааны хувьсгал манай улсад ч тусгалаа олж, өнөөдөр 20 орчим компани энэ чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулж байна. Монголд цахим худалдаа шинэ тутам хөгжиж байгаа төдийгүй иргэдийн хувьд шинэ соёл, дадал суралцаж, ухаалаг утасны ид шидээ ашиглах цаг хэдийн иржээ. Манайд цахим худалдааны дэлгүүрүүд 2014 оноос хойш идэвхжсэнээр хэрэглэгчид уламжлалт худалдаанаас бага багаар холдож буй. Хэрэглэгчдийг өөртөө татах үүднээс хүргэлтийн үйлчилгээ болон төлбөр тооцооны системийн аюулгүй байдлыг найдвартай хангахад дор бүрнээ компаниуд хөрөнгө оруулалт хийж, борлуулалтаа өсгөх арга замыг эрэлхийлэх болжээ. Эдийн засаг, бизнесийн салбарт голлох үүрэгтэй болж ирж буй цахим худалдаанд хагас их наяд төгрөгийн бараа, бүтээгдэхүүн эргэлдэж байна. Энэхүү судалгааг MEC Partners LLC хийжээ.

Үндэсний үйлдвэрлэгчдийн хувьд цахим худалдаа бол илүү том зах зээлд өрсөлдөх боломж юм. Тэрчлэн зардлаа хэмнэж, бүтээгдэхүүнээ зорилтот худалдан авагчдад хүргэх гарц гэж үздэг. Тухайлбал, MVENT компанийн гүйцэтгэх захирал Э.Гүнбилэг “Бүтээгдэхүүнээ цахимаар борлуулж, захиалга авч, хүргэж байсан нь цаг завгүй хүмүүсийн ажлыг хөнгөвчилж, компанийн борлуулалтад нөлөөлсөн” гэв. Тус компани гарааны бизнесээс үйл ажиллагаа анх эхлүүлсэн бөгөөд одоо хоёр дахь “Шагайчин” бүтээгдэхүүнээ зах зээлд гаргаж, цахимаар захиалга авч эхэлсэн байна. Өмнө нь онлайн худалдааны хуучуулын нэг Mmarket цахим дэлгүүрээр бүтээгдэхүүнээ



С.Батсайхан / ЗГМФ

борлуулж байсан бол энэ жилээс Ardshop цахим дэлгүүртэй хамтарч ажиллахаар болжээ.

Цахим худалдаа эрхэлж буй компаниудын хувьд хүргэлтийн үйлчилгээ өрсөлдөх чадварыг нь тодорхойлж байна. Хүргэлтийн үйлчилгээний хувьд орон нутгаас Орхон, Дархан-Уул аймагт захиалсан бараа, бүтээгдэхүүн хамгийн хурднаар хэрэглэгчдэд хүрдэг байна. Нөгөө талд орон нутаг дахь интернетийн хурдыг нэмж, үндэсний шуудангийн үйлчилгээгээр дамжуулан цахим худалдааг хөгжүүлэх боломж байгаа юм. Ирж буй захиалгын 40 гаруй хувь нь утсаар хийгддэг аж. Цахим худалдааны зонхилох худалдан авагчид нь 25-40 хүртэлх насны эмэгтэйчүүд байна. Компаниудын хувьд орон нутгийг маш том зах зээл гэж үзэж, цаашид аймаг, сум руу чиглэсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулахад анхаарах болсон.

Э.Гүнбилэг “Дэлхий ертөнц цахим эринд шилжин бүх зүйл хүний амьдралыг амар, хялбар болгоход чиглэж байна. Үүний нэг нь цахим дэлгүүр. Бизнес эрхлэгчид амралтгүй ажиллаж, ашиг орлогоо нэмэх боломжийг байнга эрэлхийлдэг бол худалдан авагчид хамгийн тав тухтай байдлаар хэзээ ч, хаанаас ч

хүссэнээ хайж, олоод, худалдан авах сонирхолтой. Тэгвэл энэ бүхний шийдэл нь онлайн дэлгүүр. Дундын зуучлагч байхгүй тул түрээс, нэмэлт зардал төлөх шаардлагагүй. Бизнес эрхлэгч цахим дэлгүүрээр бүрэн хянах боломжтой” хэмээн цахим худалдааны давуу талыг онцолсон.

Шинээр зах зээлд мэндэлж буй гарааны компаниуд цахим дэлгүүрийн үйлчилгээг хамгийн их сонирхдог болсон байна. Тэдний хувьд тогтсон хуримтлалгүй, санхүүгийн хувьд хувилбарыг сонгох болжээ. Цахимаар бараа, бүтээгдэхүүнээ сурталчлах, таниулах сонирхол нэмэгдэх хэрээр Монголд ирэх жилүүдэд цахим дэлгүүрийн үйлчилгээнд багагүй ахиц, дэвшил гарах хүлээлт бий болсон. Зөвхөн шинэ компаниудаар хэмжигдэхгүй хэрэглэгчдэд хэзээний хүрсэн компаниуд ч цахим дэлгүүрээр бараа, бүтээгдэхүүнээ худалдаалж байна.

Lhamour брэнд Amazon.com сайтад нэгдсэн. Ингэснээр олон улсад суугаа хэрэглэгчдэд цахимаар худалдан авалт хийхэд

илүү хялбар болсныг Lhamour брэндийн үүсгэн байгуулагч Д.Хулан онцолсон юм. АНУ болон Европоос шууд захиалга хүлээн авах боломжтойг тэрбээр тодотгов. 2017 онд анхны экспортоо Lhamour брэнд эхлүүлж байсан бол өнөөдөр дэлхий нийтийн цахим худалдааны хамгийн том сувгаар дамжуулан борлуулалтын сүлжээгээ өргөтгөхөөр болж байна. Үйл ажиллагаа явуулаад тав дахь жилтэйгээ золгосон Lhamour-ийн хувьд экспортоо нэмэгдүүлэхээр Тайланд, Австрали, Тайван, Хонконг, АНУ руу бүтээгдэхүүнээ гаргаж байна.

Интернет худалдааны Amazon.com анх ном худалдаалж эхэлсэн бол 2002 оноос хүрээгээ тэлж, хувцас болон спорт бараа борлуулж эхэлсэн байдаг. Дэлхийн хамгийн том худалдааны alibaba.com өдөр бүр 100 гаруй мянган худалдан авагчтай харилцаж, арилжаа наймаанд нь зуучилж байна. Эдгээрийг дурдахын учир нь 2000 оны эхэн үеэс эрнээ авсан цахим худалдааны бизнес ирэх жилүүдэд илүү хүчтэй томорч, хөгжиж буй орнуудад энэ төрлийн үйлчилгээ богино хугацаанд шинэ шатанд гарах төлөвтэйг The Economist сэтгүүл хөнджээ.

● Манайд цахим худалдааны дэлгүүрүүд 2014 оноос хойш идэвхжсэнээр хэрэглэгчид уламжлалт худалдаанаас аажмаар холдож буй.

● Цахим худалдаа эрхэлж буй компаниудын хувьд хүргэлтийн үйлчилгээ өрсөлдөх чадварыг нь тодорхойлж байна.

● Шинээр зах зээлд мэндэлж буй гарааны компаниуд цахим дэлгүүрийн үйлчилгээг хамгийн их сонирхдог.

Технологи сайжрах тусам Монголын цахим худалдааны компаниудад боломж нэмэгдэнэ. Тухайлбал, манай улсад 2017-2018 онд цахим дэлгүүрүүд нэгдэн нийлэх, шинэ хөрөнгө оруулагчтай болох үйл явц

эрчимжжээ. Монголд онлайн худалдааны нэгдсэн үйлчилгээ үзүүлдэг 20 гаруй платформ бий. Цахим худалдааны гүйлгээний 90 орчим хувийг интернэт банкаар хийж байгаа аж. Сүүлийн хэдхэн жилийн хугацаанд цахим дэлгүүрүүд бараа, бүтээгдэхүүний сонголтоо нэмэгдүүлж, төрөлжүүлж, цэс цэсэнд хуваарилах болсон. Ингэснээр аль болох хэрэглэгчдэд илүү дөхөм байдлаар сонголтоо хийхэд нь туслах үүднээс сайтын хөгжүүлэлт ч өнгө, үзэмжээ нэмж байна. Тэрчлэн хамгийн бодит хямдралыг цахим дэлгүүрүүдэд хэрэглэгчдэд олгох болсон. Тухайлбал, 30-50 хүртэл хувиар хямдрал зарлах жишээтэй. Энэ нь хэрэглэгчдийг хамгийн бодитой татах үзүүлэлт болж байна. shoppymn цахим дэлгүүр гэхэд бүхий л бараа, бүтээгдэхүүндээ 20-50 хүртэлх хувийн хямдрал зарлажээ. Харин Facebook-г 100 орчим цахим дэлгүүр байна. Эдгээр нь улсад татвар төлдөггүй бөгөөд хүргэлтийн үйлчилгээ ч төдийлэн сайн хөгжөөгүй байгаа юм. Хэдий тийм боловч цахим худалдааны талбарт томоохон орон зай эзэлж буй. Тэднийг үйл ажиллагааг хууль бус худалдаа гэж компаниуд үздэг. Тэгвэл зарим компани “Монгол Шуудан” компаниар дамжуулан хэрэглэгчдэдээ бараа, бүтээгдэхүүнээ хүргэдэг болжээ.

Монголд цахим худалдаанд эргэлдэж буй мөнгөн дүнг нарийн тооцон гаргах боломжгүй гэсэн тайлбарыг салбарынхан өгч байна. Учир нь, дийлэнх нь Facebook-ээр дамжиж хувь хүмүүсийн хооронд гүйлгээ хийгдэх нь их бөгөөд “хар зах” маягийн энэ байдлыг барагцаалахад хүндрэлтэй аж. Интернет худалдааны дотоодын зах зээл сүүлийн таван жилд эрчтэй хөгжиж байгаа хэдий ч нарийн тоо, баримттай судалгаа энэ салбарт одоо хүртэл дорвитой хийгдээгүй байна. Монголд цахим худалдааны платформуудын гол өрсөлдөгч нь Facebook гэж салбарынхан үзэж байгаа юм. Олон нийтийн уг аварга сүлжээгээр дамжуулан өдөрт 60-70 орчим мянган худалдан авалт хийгдэж байгаа гэсэн тооцоо бий. Цахим худалдааны хөгжилд хүргэлтийн үйлчилгээ ч тээг болсон хэвээр. [ЗГМ]

БИЗНЕС Citigroup-ийн бонд арилжааны орлого 21 хувиар буурчээ

Citigroup-ийн үнэт цаасны гол бизнес болох бонд арилжааны орлого 2018 оны IV улиралд 21 хувиар буурчээ. Хэдий тийм боловч хамгийн хүнд үе ард хоцорч, энэ сараас бонд арилжааны бизнесийн

арилжааны орчин сайжирч эхэлсэн гэж тус банкны Санхүү харниусан захирал Жон Герспак мэдэгдлээ. Зах зээлийн савлагаа харьцангуй эерэг түвшинд шилжиж, ханш болон өгөөж аль аль нь тогтворжих өнгө

аяс ажиглагдаж эхэлсэн гэж тэрбээр тайлбарлаж байна. Гэхдээ зах зээл бүрэн сэргэсэн гэхэд хэтэрхий эрт байгааг анхааруулжээ. IV улирлын тайлангаас нь харвал Citigroup-ийн нэгдэн, нийлэх

хэлцлийн талаарх зөвлөх үйлчилгээний орлого 47 хувиар, зээлийн картын салбар нэгжийн орлого нэг хувиар өсжээ. Мөн улирлын дүнгээр зардлаа дөрвөн хувиар танасан нь санхүүгийн үзүүлэлтийг нь

дэмжсэн байна. Түүнчлэн энэ жил банкны татварын зардал тооцоолсноос бага байх тул нэгж хувьцааны ногдол ашиг нь нэмэгдэх төлөвтэй байгаа юм байна. Энэхүү мэдээллийн дараа Citigroup-ийн хувьцааны ханш

дөрвөн хувиар өсөж, S&P 500 индексэд өсөлтөөр тэргүүлжээ. 2018 он олон улсын санхүүгийн зах зээлийн хувьд багагүй доргионтой болж өнгөрсөн. Үүний тусгал дээрх байдлаар нөлөөлжээ.

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

